



Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Эцсийн тайлан

Агуулга

Хураангуй дүгнэлт	5
Аргачлал.....	1
I. Стартапуудын товч танилцуулга	2
II. Гүйцэтгэл.....	5
Экосистемийн үнэлгээ.....	5
Стартапын үнэлгээ.....	6
Гарах үеийн үнэлгээ	7
Стартапын амжилт	8
III. Санхүүжилт	9
Анхны санхүүжилт	10
Явцын санхүүжилт	11
IV. Зах зээлд нэвтрэх	14
Дотоодын зах зээл.....	14
Дэлхийн зах зээл.....	16
V. Туршлага, авьяас мэдлэг	16
Туршлага	17
Авьяас мэдлэг	18
Оюуны өмч	19
VI. Уялдаа холбоо	22
Стартапууд.....	22
Хурдасгуур/Инкубаторууд.....	23
Томоохон компаниуд	25
Их дээд сургууль, коллеж.....	25
Төрийн байгууллагууд	29
VII. Стартап экосистемийн тулгамдаж буй асуудлууд.....	36
Олон улсын туршлага.....	39
VIII. Стартапын экосистемийг хөгжүүлэх зөвлөмж	42

Зургийн жагсаалт

Зураг 1: Боловсрол, n=80	2
Зураг 2: Үүсгэн байгуулагч багийн гишүүдийн тоо, n=80.....	2
Зураг 3: Үүсгэн байгуулагчдын нас-хүйсийн суварга, n=80.....	2
Зураг 4: Стартапууд, хөгжлийн үе шатаар (тоогоор), n=80.....	3
Зураг 5: Стартапууд бүтэц, салбараар, n=80	3
Зураг 6: Стартапуудын бүтэц, дэд салбараар, n=80.....	4
Зураг 7: Үнэлгээгээ хийсэн стартапын тоо ба тэдгээрийн дундаж үнэлгээр, тэрбум төгрөгөөр, хөгжлийн үе шатаар, n=46.....	6
Зураг 8: Стартапын үнэлгээний дүн, тэрбум төгрөг, дэд салбараар, n=46	7
Зураг 9: Стартапын гарах үеийн үнэлгээний дүн, дэд салбараар, тэрбум төгрөг, n=19	8
Зураг 10: Анхны санхүүжилтийн эх үүсвэр, n=80	10
Зураг 11: Анхны санхүүжилтийн дундаж хэмжээ, дэд салбараар, сая төгрөг, n=80.....	11
Зураг 12: Явцын санхүүжилтийн эх үүсвэр, n=41	12
Зураг 13: Явцын санхүүжилтийн дундаж хэмжээ, хөгжлийн үе шатаар, сая төгрөг, n=41.....	12
Зураг 14: Явцын санхүүжилтийн дундаж хэмжээ, дэд салбараар, төгрөг, n=41	13
Зураг 15: Хөрөнгө оруулалт авахад тулгардаг гол бэрхшээл, n=80.....	13
Зураг 16: Технологид суурилсан стартапуудын зах зээлийн ангилал, n=80.....	15
Зураг 17: Орлогоороо тэргүүлж буй стартапын 5 дэд салбар, орлогоор (сая төгрөг.)	15
Зураг 18: Мэдээллийн технологийн мэргэжилтнийг ажил авдаг арга зам, n=80	18
Зураг 19: Багт хамгийн их шаардлагатай ур чадвар, n=80	19
Зураг 20: Хамтын ажиллагаа, байгууллагаар, n=80.....	23
Зураг 21: Хамтын ажиллагааны төрөл, байгууллагаар, n=80.....	23
Зураг 22: Монгол улсын Инновацийн тухай хуульд заасны дагуу Инновацийн дэд бүтцийн оролцогч талууд.....	32
Зураг 23: ШУТС-гийн санхүүжилт, судалгааны төрлөөр.....	35
Зураг 24: Стартапуудын гол бэрхшээл, n=80	36
Зураг 25: Стартапуудад тулгардаг бэрхшээл, хөгжлийн үе шатаар, n=80.....	36
Зураг 26: Стартапуудын төрөөс хүсэж буй тусламж, n=80	37
Зураг 27: Монголын стартапыг хөгжүүлэх чухал хүчин зүйлс, n=80.....	38

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1: ДСЭТ-ын гүйцэтгэлийн үзүүлэлтүүд, n=80	5
Хүснэгт 2: Судалгаанд хамрагдсан стартапуудын анхны санхүүжилтийн хэмжээ	10
Хүснэгт 3: Судалгаанд стартапуудын тооцноор нэмэлт санхүүжилтийн үзүүлэлт	11
Хүснэгт 4: ДСЭТ-ын зах зээлийн нэвтрэлтийн үзүүлэлт.....	14
Хүснэгт 5: Гадаадын зах зээлд нэвтрэх, өрсөлдөхөд тулгарах гол асуудлууд.....	16
Хүснэгт 6: ДСЭТ дахь туршлага ба авьяасын үзүүлэлтүүд	16
Хүснэгт 7: Үүсгэн байгуулагч нарын хувийн давуу тал, n=80.....	17

Товчилсон үгийн тайлбар

₮	Монгол төгрөг
ISIC	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал
ам.доллар	АНУ-ын доллар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДСЭТ	Дэлхийн стартап экосистемийн тайлан
ЖАЙКА	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
МТ	Мэдээллийн технологи
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МХТ	Мэдээлэл, холбооны технологи
ОӨ	Оюуны өмч
СХ /R&D/	Судалгаа ба хөгжүүлэлт
ТББ	Төрийн бус байгууллага
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХН	Хүний нөөц
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭУБГ	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
ШУТС	Шинжлэх ухаан, технологийн сан
ШУТИМ /ШУТИМ/	Шинжлэх ухаан, технологи, инженер, математик

Хураангуй дүгнэлт

2021 оны СтартапБлинкийн Стартап экосистемийн дэлхийн индексээр, Монгол улс дэлхийн шилдэг 100-аас 88-д жагсаж байна (2020 оноос 5 байр урагшилсан үзүүлэлт). Мөн 2021 онд Монгол улс анх удаагаа дэлхийн шилдэг Софтвр датагаараа 67-р байранд орсон. Улаанбаатар хот хоёр дахь удаагаа 2020 оны 690 дүгээр байрнаас 199 байр урагшилж, 1000 хотоос 491 дүгээр байранд жагссан байна. Тус тайланд Монгол улсын стартап экосистем одоогоор хөгжлийн үе шатандаа байгаа гэж үзсэн бөгөөд засгийн газраас хэрэгжүүлж буй дижитал улс арга хэмжээ болон өсөн нэмэгдэж байгаа технологийн салбарын мэргэжилтнүүд нь өсөх ирээдүйтэй болохыг илтгэж байна гэж дурджээ.

“Танай энтрепренерүүд ид шидийг бүтээх авьяас билигтэй.
Тэдэнд зориулж дэд бүтцийг нь бэлэн болго”.
Eli David, CEO, StartupBlink

Стартап экосистемийн зорилго нь дэлхийн өртгийн сүлжээнд өрсөлдөх чадвар бүхий технологид суурилсан стартапыг гаргах, хөгжүүлэх юм. Дэлхий даяар стартап үүсгэн байгуулагчид болон хөрөнгө оруулагч нар юникорн болох боломжийг нэмэгдүүлсэн хамгийн шилдэг экосистемийг хайж байдаг. Ийм шилдэг стартапын экосистемийн бодлого боловсруулагчид стартапын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын таатай орчныг бүрдүүлэхээр хоорондоо өрсөлдөж байдаг.

Энэ судалгааны тайлан нь Монгол улсын стартап экосистемийн потенциалыг хэмжих, бодлого боловсруулагчид, хөрөнгө оруулагчид, олон улсын хөгжлийн байгууллагууд, хувийн секторынхны анхаарлыг технологид суурилсан стартапуудад хандуулах, хүний нөөцийг хөгжүүлэх ажлыг хамгийн чухалд эрэмбэлүүлэхээр зорьж байна. Нийт 80 стартап, 10 инкубатор, хурдасгуур компани, инновацийн төв, бүлгэм, 9 их дээд сургууль, технологийн коллеж, судалгааны институтүүд болон төрийн, олон улсын байгууллагын төлөөллүүд судалгаанд хамрагдсан.

Судалгаанд хамрагдсан стартапуудын мэдээлснээр, **Монгол улсын стартап экосистемийн нийт үнэлгээ дунджаар дор хаяж 452 тэрбум төгрөг** байна. **Нийт 96 тэрбум төгрөгийн хөрөнгийг тэд босгосон байна.** Судалгаанд оролцсон стартапууд **нийт 60 тэрбум төгрөгийн орлого олсон бөгөөд 1318 ажлын байрыг бий болгосны 717 нь бүтэн цагийн ажлын байр** байна.

Стартап экосистемийн хувь нэмрийг аялал жуулчлалын салбартай харьцуулбал илүү ойлгомжтой. Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны мэдээллээр, 2021 онд аялал жуулчлалын салбар ДНБ-ний 0.5 хувь буюу 54 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Монгол улсын стартап экосистем нь харьцангуй залуу бөгөөд стартапууд дунджаар 3.6 жил үйл ажиллагаа явуулж байгаагийн 63% нь сүүлийн 3 жилд үйл ажиллагаагаа эхлүүлжээ. Ялангуяа, судалгаанд оролцогч стартапуудын 32% нь 2021 онд үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. 90% нь Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ)-т бүртгэлтэй байна. Стартапууд нийт 137 оюуны өмч бүртгүүлснээс 10 нь олон улсад бүртгэгдсэн ба бүгд зах зээлд нэвтэрсэн байна. Стартапын үүсгэн

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

байгуулагчид нь маш сайн боловсрол эзэмшсэн байгаагаас 48% нь дээд боловсролтой, 44.6% нь ШУТИМ-н зэрэгтэй байна. Үүсгэн байгуулагчид дунджаар 2.4 стартапыг үүсгэн байгуулсан бөгөөд хангалттай мэргэжлийн ур чадвар, туршлагатай байна. Гэсэн хэдий ч стартап экосистемийн хувьд цаашид хөгжихийн тулд асуудлуудыг шийдэх шаардлагатай ба эдгээрийн ихэнх нь хууль эрхзүйн орчныг өөрчлөх, төрөөс тогтвортой дэмжлэг үзүүлэхтэй холбоотой байна.

Стартапын түвшинд **хамгийн тулгамдсан асуудал нь хүний нөөцийг бүрдүүлэх (63%)**, хөрөнгө босгох (55%), борлуулалт хийх, харилцагчаа нэмэгдүүлэх (49%), багаа хөгжүүлэх (38%), гадаад зах зээлтэй холбогдох (35%) байна. Хамгийн хэрэгтэй байгаа топ-5 дэмжлэг нь: хөрөнгө оруулалтын сан (61%), татварын бодлогыг сайжруулах (54%), татаас урамшуулал (40%), инноваци, оюуны өмчийг хамгаалах бодлого (39%), зээл тусламж (31%) байна.

Стартапууд Монгол улсын стартап экосистемийг хөгжиж байгаа гэж үзэж байгаа бөгөөд экосистемийн хөгжилд нөлөөлөх топ-5 хүчин зүйлийг тодорхойлсон. Үүнд боловсролтой ажиллах хүчин (68%), эдийн засгийн тогтвортой орчин (59%), инновацийн түвшин (41%), хүн амын худалдан авах чадвар (34%), болон багийн гишүүдийн хүрэлцээ (29%) зэргийг нэрлэж байна.

Төрийн байгууллагуудын хувьд Монгол улсын стартап экосистемийн хөгжлийн тухайд илүү сөрөг хандлагатай байна. Тэд инновацийг дамжуулах, кластераар хөгжих, бодлогын хувьд сайжруулах хэрэгтэй гэж үзэж байна. Мөн түүнчлэн хөрөнгө оруулагчдын тоо цөөн байгаа нь стартапуудын хөгжилд тушаа болж байна. Олон улсын хөгжлийн байгууллагуудын хувьд стартапыг хөгжүүлэхэд **төрөөс тууштай дэмжих нь хамгийн чухал хүчин зүйл** гэж үзэж байна. Тэд мөн төрийн оролцоо нь илүү таатай бодлогын орчныг бий болгож, сайн судалгааны үндсэн дээр хийгдэх ёстой гэж үзэж байна. Бид мөн Япон, Сингапур улсын экосистемүүдийг судалж үзсэн бөгөөд Эстони, Литва улсын стартап экосистемээ дэмжих сайн туршлагын жишээг тайландаа багтаасан.

Гол оролцогч талуудын санаа бодолд үндэслэн, бид стартап экосистемийг хөгжүүлэх дөрвөн гол үйл ажиллагааг санал болгож байна. Үүнд:

1. **Стартапын эдийн засгийн хөгжлийг дэмжих хууль эрхзүйн орчныг бий болгох:** Бизнесийн орчны глобал инновацийн индексээр 2021 (GII-2021) Монгол улс 110-р байранд жагсаж байна. Засгийн газар нь гадаадын хөрөнгө оруулагчдыг татах гол тоглогч байж болох бөгөөд хувийн секторын туршлага мэдлэгт үндэслэн стартап экосистемийг хөгжүүлэх боломжтой. Энэ санааг олон улсын байгууллагуудыг оролцуулан бүх оролцогч талууд дэмжиж байна. Хууль эрхзүйн зохицуулалтыг шинэчилснээр гол оролцогч талуудын хоорондын уялдаа холбоог сайжруулж, тэдний чадавхыг бэхжүүлнэ.
2. **Стартапууд болон хөрөнгө оруулагчдад зориулсан хөшүүрэг:** Улс орнууд стартап экосистемээ дэмжиж байгаагаар илэрхийлэн стартап болон хөрөнгө оруулагч нартаа төрөл бүрийн хөшүүрэг дэмжлэгийг бий болгодог. Литва улс нь стартапын хөгжлийн үе шатуудад тохируулан ийм хөшүүргүүдийг бий болгосон хамгийн сайн жишээ юм. Татварын хөшүүрэг, бизнесийн илүү таатай орчин нь стартапад хөрөнгө оруулалт татах чухал хүчин зүйлс болно.
3. **Стартап экосистемийн уялдаа холбоог сайжруулах:** Монгол улс инновацийн уялдаа холбоогоороо #123-т, мэдлэгийн хэрэглээгээрээ #124-т жагсдаг (GII-2021). Дотоод болон гадаад уялдаа холбоо сул байна. Тиймээс стартап экосистемийн гол оролцогч талууд хоорондын уялдаа холбоогоо нэмэгдүүлэх, сурталчлах шаардлагатай. Стартапын холбоо

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

нийгэмлэг байгуулах, мэдээллийн сантай болох зэрэг нь стартап экосистемийн уялдаа холбоог сайжруулж болох тодорхой жишээнүүд юм.

4. **Инноваци хүний нөөцийг дэмжих ШУТИМ-ын боловсролын шинэчлэл хийх:**
Хүний нөөц, судалгаа шинжилгээний хувьд Монгол улс #81-р байранд эрэмбэлэгддэг. Боловсролтой мэргэжлийн хүний нөөц нь Монгол улсын стартап экосистемийг хөгжүүлэх түлхүүр хүчин зүйл юм. ШУТИМ-ын хөтөлбөрүүдэд элсэгчдийн тоо багасаж байгаа нь төрийн зүгээс ШУТИМ-ын боловсролын шинэчлэлийг хийх цаг болсныг илтгэж байна.

Аргачлал

Энэхүү үнэлгээнд стартапыг авч үзэхдээ салбартаа үсрэнгүй өөрчлөлтийг авчрахыг зорьж буй технологид суурилсан гарааны бизнес хэмээн хязгаарласан. Бусад экосистемтэй харьцуулахын тулд шинээр гарч ирж буй экосистемийг хэмжих Стартапын Геном байгууллагын Дэлхийн Стартапын Экосистемийн Тайлангийн (ДСЭТ) аргачлалыг суурь аргачлал болгон сонгон авсан. Энэ аргачлал нь экосистемийн хөгжлийн дараахь 4 үндсэн үзүүлэлт, мөн нэг нэмэлт чанарын үзүүлэлтийг ашигладаг. Үүнд:

- Гүйцэтгэл;
- Санхүүжилт;
- Зах зээлд нэвтрэлт;
- Туршлага, авьяас мэдлэг;
- Уялдаа холбоо (нэмэлт).

Монгол улсын стартапын экосистемийг үнэлэхэд тулгардаг гол асуудал нь стартапын экосистемийг хэмжих дэлхийн хэмжээний найдвартай гуравдагч талын мэдээллийн эх үүсвэрийн дутагдалтай байдал юм. Жишээлбэл, ДСЭТ-д Crunchbase, Dealroom зэргийг гуравдагч талын мэдээллийн эх үүсвэр болгон ашигладаг. Үүний зэрэгцээ, ДСЭТ нь глобал үүгэн байгуулагчдын судалгаа болон суурь судалгааг ашигладаг. Тиймээс, бид стартап экосистемийн гол оролцогч талуудтай ярилцлага хийх байдлаар аргачлалаа чанарын үнэлгээ болгон өөрчилсөн. Ярилцлагад нийтдээ 80 стартап, 10 хурдасгагч/инкубатор болон инновацийн төвүүд, 9 их сургууль болон технологийн коллежууд (KOSEN), олон улсын хөгжлийн байгууллагууд болон төрийн байгууллагуудын төлөөлөл оролцсон. Стартапын салбарын ангиллыг мөн Стартапын Геном байгууллагын ДСЭТ-д ашигласан ангилал бага зэрэг нэмэлт өөрчлөлт хийн ашигласан.

Экосистемийн үнэлгээ болон жилийн орлого нь стартапуудын ярилцлагын үеэр өгөх хариулт дээр суурилсан учраас баталгаажуулах боломжгүй. Тиймээс, салбарын бодит үнэлгээ гэхээсээ илүүтэйгээр тухайн салбарын потенциалыг харуулах зорилгоор тооцоолсон үнэлгээг гаргаж ирсэн. Үүн дээр нэмээд дээш эсвэл доош хазайлтыг бууруулахын тулд хариултын интервалын дундаж утгыг ашигласан.

Интервал бүрийн гол цэгийн утгыг болгон тухайн интервалын дундаж болгон ашигласан. Дараа нь эдгээр гол цэгүүдийн утгыг тухайн бүлэгт хамаарах давтамжаар үржүүлсэн. Үржвэрүүдийн нийлбэрийг үнэлгээнд хамрагдсан нийт нэгжийн тоонд хувааснаар дундаж үнэлгээг тооцож, энэ аргыг ашиглан экосистемийн үнэлгээ, жилийн борлуулалтын орлого, бусад үзүүлэлтийг тооцоолсон.

Судалгаанд оролцсон стартапуудын гаралтын үнэлгээ болон нийт болон стартапын дундаж үнэлгээ зэрэг экосистемийн үнэлгээг Гүйцэтгэлийн үзүүлэлт болгон тооцсон. Санхүүжилтийн үзүүлэлтийн хувьд анхны болон явцын санхүүжилтийн нийт дунджийг санхүүжилтийн эх үүсвэрээр нь авч үзсэн.

Мэдээллийн хязгаарлагдмал байдлын улмаас Монголын стартапын зах зээлийн хүртээмжийг ДСЭТ-ийн аргачлалын дагуу тооцоолох боломжгүй болсон. Гэхдээ бид өнөөгийн нөхцөл байдлыг бусад нэмэлт үзүүлэлтээр, тухайлбал стартапуудын зорилтот зах зээлийн талаарх ойлголт, зорилтот зах зээлд хэчнээн хувийг эзэлж байгаа, стартапуудын борлуулалтын орлого зэрэг үзүүлэлтийг ашиглаж Монголын эдийн засагт стартапуудын гүйцэтгэх үүргийг ойлгохыг хичээсэн. Авьяас ба туршлагын хувьд стартап үндэслэгч нарын авьяас болон туршлагыг нь судалсан болно.

I. Стартапуудын товч танилцуулга

“Гарааны бизнесүүд нь инноваци дээр суурилж, одоо байгаа бүтээгдэхүүний дутагдлыг арилгах эсвэл бараа, үйлчилгээний цоо шинэ ангиллыг бий болгож, улмаар бүхэл бүтэн салбарыг хамарсан сэтгэх, бизнес эрхлэх хэв маягийг өөрчилдөг.” (The Forbes).


Монгол улсын стартапын экосистемийн суурь судалгаанд нийт 80 технологид суурилсан стартапын үүсгэн байгуулагчийг оролцуулсан.

Ерөнхийдөө Монгол улсын стартап экосистем нь харьцангуй залуу буюу стартапуудын бараг 63 хувь нь сүүлийн 3 жилд үйл ажиллагаа явуулж байгаа стартапууд байна. Тухайлбал, судалгаанд оролцсон стартапуудын 32 хувь нь 2021 онд байгуулагджээ. 90 хувь нь Монгол улсын УБЕГ-т албан ёсоор бүртгүүлсэн ба үйл ажиллагаагаа явуулаад дунджаар 3.6 жил болж байна. Стартапыг үүсгэн байгуулагчид нь өндөр боловсролтой, 49 хувь нь ахисан түвшний боловсролтой бол 44.6 хувь нь ШУТИМ зэрэгтэй байна. Судалгаанд оролцсон стартапууд дунджаар 2, дээд тал нь 5 үүсгэн байгуулагчтай байна. Стартапуудын талаас илүү хувийг нь дан эрэгтэйчүүдээс бүрдсэн баг (54%) байгуулсан бол дан эмэгтэйчүүдээс бүрдсэн баг нь 14 хувийг эзэлж байна. Харин эрэгтэй, эмэгтэй холимог үүсгэн байгуулагчидтай стартап 32 хувийг эзэлж байна.

Зураг 1: Боловсрол, n=80




Зураг 2: Үүсгэн байгуулагч багийн гишүүдийн тоо, n=80



Үүсгэн байгуулагчдын хүйсийн харьцааны хувьд 65 хувь нь эрэгтэй, 35 хувь нь эмэгтэй байна. Тэд харьцангуй залуу ба дундаж нас нь 34 байна (хамгийн залуу нь 22 настай бол, хамгийн ахмад нь 51 настай).

Зураг 3: Үүсгэн байгуулагчдын нас-хүйсийн суварга, n=80




Судалгаанд оролцсон стартапууд нь дунджаар 20 ажилтантай байна. Судалгаанд оролцсон 80 стартап нийт 1318 ажлын байрыг бий болгосны 717 нь орон тооны, 601 нь цагийн ажилтан байна. Орон тооны ажилчдын хамгийн их тоо нь 33 бол байгаа бол хамгийн их цагийн ажилтаны тоо нь 300 байна.

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Санаагаа хөгжүүлэх болон бета/прототайп хөгжүүлэлтийн үе шатан дахь стартапууд 24%-ийн эзэлж байгаа бол 69 хувь нь орлого олж эхлэх үе шатнаас шинэ зах зээл рүү нэвтрэх өсөлтийн үе шатандаа байна гэж үзжээ. Харин стартапуудын 7% нь тогтворжилтын шатандаа орсон гэж үзэж байна.


Зураг 4: Стартапууд, хөгжлийн үе шатаар (тоогоор), n=80



Стартапууд үүсэн байгуулагдаж буй динамикийг ойлгохын тулд бид 2021 онд байгуулагдсан шинэ компаниудыг авч үзсэн. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар (ХЭУБГ) мэдээллээр 2021 онд Монгол улсад 13,519 хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) шинээр байгуулагдсан байна. Монгол улсын Үндэсний статистикийн хорооны (ҮСХ) мэдээллээр 2021 оны 12 сарын байдлаар 73,221 ХХК идэвхтэй үйл ажиллагаа явуулж байжээ. ХЭУБГ болон ҮСХ аль аль нь Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллыг (ISIC) ашигладаг. ISIC болон ДСЭТ-гийн салбарын ангилал нь ялгаатай байгаагаас энэхүү судалгааны үр дүн болон албан ёсны

статистик мэдээллийг харьцуулах боломжгүй.

Зураг 5: Стартапууд бүтэц, салбараар, n=80



Хэрэв бид судалгаанд оролцсон стартапуудыг ДСЭТ-ын дагуу ангилбал гол давамгайллагч салбарууд нь МХТ (44%), боловсрол (14%), эрүүл мэнд (14%) байна. Судалгаанд оролцсон стартапуудыг ДСЭТ аргачлалын дагуу дэд салбараар ангилсан (үүн дээр и-арилжаа, хуулийн технологи, веб, апп хөгжүүлэгч зэрэг ангиллыг нэмж оруулсан). ДСЭТ-ын дэд салбарын ангиллаар стартапууд нь гол төлөв боловсролын технологи (36%) байгаа бол үүний дараа AI, их өгөгдөл ба аналитик (26%), Зар сурталчилгаа/Маркетингийн технологи (25%)-ийн дэд салбар орж байна. Боловсролын эрэлт хэрэгцээ өндөр байгаа учраас Боловсролын технологи (тоогоор)-ийн стартапууд стартапын салбарыг тэргүүлж байна. Харин Финтек болон Блокчэйнийн дэд салбар нь орлогоор тэргүүлж байна

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Зураг 6: Стартапуудын бүтэц, дэд салбараар, n=80



II. Гүйцэтгэл

ДСЭТ-ын аргачлалд гүйцэтгэлийг хэмжих экосистемийн үнэлгээ, гаралт болон стартапын амжилт гэсэн гурван үндсэн үзүүлэлтийг авч үзсэн байдаг.

Хүснэгт 1: ДСЭТ-ын гүйцэтгэлийн үзүүлэлтүүд, n=80

Үзүүлэлт	Дэд үзүүлэлт	Монголын стартапуудын үнэлгээ
Экосистемийн үнэлгээ	Стартапын тооцоолсон үнэлгээний дүн	₮ 423.9 Т
	Гарах үнэлэмжийн дүн	₮ 28.2 Т
	Нийт экосистемийн үнэлэмж*	₮ 452.1 Т
Гаралт	\$ 50 саяас дээш үнэлгээтэй гаралтын тоо	Байхгүй
	\$1 тэрбумаас дээш үнэлгээтэй гаралтын тоо	Байхгүй
Стартапын амжилт	Өсөлтийн шатны амжилт	
	С-А ангиллын стартапын тоо	Байхгүй
	Юникорн (Unicorns)-ын тоо	Байхгүй
	Гарах хурд	
	Гарах үеийн компанийн дундаж нас	5 жил орчим
	Анхдагч зах зээлд хувьцаагаа санал болгох үеийн компанийн дундаж нас	4 жил орчим
	Эхэн шатны амжилт	
	В-А ангиллын стартапын тоо	Байхгүй

Жич: * - Давхардсан тооцоолол. Гарах үнэлгээ болон тооцоолсон үнэлгээний нийлбэрээр тооцсон.

\$50 сая ба \$1 тэрбумаас дээш үнэлгээтэй гаралт, өсөлтийн шатны амжилт, эхэн шатны амжилт зэрэг зарим гүйцэтгэлийн үзүүлэлтийг судалгаанд стартапуудын өгсөн мэдээлэлд үндэслэн тооцоолох боломжгүй. ДСЭТ нь StartupGenome.com, Crunchbase.com, Dealroom.co зэрэг гуравдагч талын мэдээллийн сангаас мэдээлэл цуглуулдаг бөгөөд Монголын стартапууд нь эдгээр мэдээллийн санд ороогүй байдаг. Тиймээс стартапын үнэлгээ, гаралт, борлуулалтын орлого болон бусад байгууллагын нууцтай холбоотой мэдээллийг судалгаанд оролцсон стартапуудын өөрийн үнэлгээ, хариултаас авч тооцсон. Түүнчлэн, мэдээллийн нууцлалыг хамгаалах зорилгоор судалгаанд гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг цуглуулахдаа абсолют утгаар нь бус интервалаар асуусан.

Экосистемийн үнэлгээ

Экосистемийн үнэлгээг ДСЭТ-ын дагуу стартапын өөрийн үнэлгээ болон гарах үнэлгээний нийлбэрээр тооцсон. Судалгаанд оролцсон стартапуудын хариулт дээр үндэслэн стартапын нийт үнэлгээг 423.9 тэрбум төгрөг гэж тооцсон бөгөөд стартапын дундаж үнэлгээ нь 9.2 тэрбум төгрөг

СТАРТАПЫН НИЙТ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

423.9

тэрбум төгрөг

ГАРАХ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

28.2

тэрбум төгрөг

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

байв (судалгаанд оролцсон стартапуудын дурдсанаар). Гарах үнэлгээний дүн нь 28.2 тэрбум төгрөг орчим байгаа бол дундаж гарах үнэлгээ нь 1.5 тэрбум төгрөг байна.


Экосистемийн үнэлгээ нь ярилцлагын үеэр стартапуудын хэлсэн хариулт дээр үндэслэсэн учраас баталгаажуулах боломжгүй. Түүнээс гадна, дээш/доош хазайлтыг бууруулахын тулд интервалаар өгөгдсөн хариултын дундаж үнэлгээгээр тооцсон. Тиймээс өөрийн үнэлгээг тухайн салбарын бодит үнэлгээ гэхээсээ илүү салбарын потенциалыг харуулах зорилгоор л гаргасан гэж үзэж болно.

Стартапын үнэлгээ

Судалгаанд оролцсон стартапуудын 56.3 хувь нь компанийн үнэлгээгээ хийсэн бөгөөд түүнээс зөвхөн 10 хувь нь (ихэвчлэн хөрөнгө оруулагч эсвэл хурдасгагч нараас санхүүжилт босгосон эсвэл босгох гэж байгаа орлогын өсөлтийн шатандаа байгаа компаниуд) Сократус, Ард кредит, Рино Ассет, Стандарт инвестмент зэрэг гуравдагч этгээдээр үнэлгээгээ хийлгэжээ. Үлдсэн 46.3 хувь нь компанийнхаа үнэлгээг дотооддоо өөрсдөө хийсэн байна. Харин 44 хувь нь стартапын үнэлгээгээ хийгээгүй байна.

Стартапын дундаж үнэлгээ нь 9.2 тэрбум төгрөг байгаа бол, хамгийн өндөр үнэлгээ нь 125.0 тэрбум төгрөг байна. Хөгжлийн үе шат нь дээшлэх тутам стартапуудын дундаж үнэлгээ нь нэмэгддэг байна.

Зураг 7: Үнэлгээгээ хийсэн стартапын тоо ба тэдгээрийн дундаж үнэлгээ, тэрбум төгрөгөөр, хөгжлийн үе шатаар, n=46



Стартапын үнэлгээг дэд салбараар авч үзвэл хамгийн өндөр үнэлгээтэй дэд салбарууд нь Финтек (₮ 248.8 тэрбум), Эрүүл мэндийн технологи (₮ 66.0 тэрбум) болж байна. Үйлчлүүлэгчдийн тоо, Монгол улс дахь санхүүгийн үйлчилгээний эрэлт хэрэгцээнээс шалтгаалан Финтекийн салбар хамгийн өндөр үнэлгээтэй дэд салбар болж байна. Манай судалгаанд хамрагдсан стартапуудыг

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

үзэхэд Блокчэйн болон Хиймэл оюун ухааны (AI) дэд салбарууд нь бусад салбараас илүү Финтекийн салбартай уялдаж байна. Дэд салбарын хувьд стартапууд хэд хэдэн дэд салбарт хамаарч байна (ө.х нэг стартап финтек / блокчэйн зэрэг хэд хэдэн салбарт хамаарагдаж болно).

Зураг 8: Стартапын үнэлгээний дүн, тэрбум төгрөг, дэд салбараар, n=46



Гарах үеийн үнэлгээ

Судалгаанд оролцсон стартапуудын 24 хувь нь буюу 19 нь өөрийн хөрөнгөө хэсэгчлэн борлуулсан байна. Үүнээс 5 хувь нь анхан зэх зээлд хувьцаагаа гаргасан бол 95 хувь нь томоохон компаниудад хувиараа санал тавих байдлаар борлуулсан байна. Нийт гарах үеийн үнэлгээ нь ойролцоогоор 28.2 тэрбум төгрөг байна.

Стартапын гарах үеийн нийт үнэлгээ нь анхны нийт хөрөнгө оруулалтаас 12 дахин нэмэгджээ.

Хэсэгчлэн гарсан стартапын анхны санхүүжилтийн дүн

2.3

тэрбум төгрөг

x12

Хэсэгчлэн гарах үеийн стартапын үнэлгээний дүн

28.2

тэрбум төгрөг

Өөрийн хөрөнгийг хэсэгчлэн борлуулсан стартапуудын хувьд гарах үнэлгээний дүн асар их буюу анхны хөрөнгө оруулалтаасаа 12 дахин нэмэгджээ.

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Салбараар нь авч үзвэл, Зар сурталчилгааны ба маркетингийн технологийн стартапууд хамгийн өндөр гарах үнэлгээтэй (₮ 9.7 тэрбум) байгаа бол Вэб ба апп хөгжүүлэлт (₮ 6.1 тэрбум), AI, их өгөгдөл, аналитик (₮ 3.8 тэрбум) түүний дараа орж байна. Гарах үеийн дундаж үнэлгээ ₮ 9.7 тэрбум байжээ.

Зураг 9: Стартапын гарах үеийн үнэлгээний дүн, дэд салбараар, тэрбум төгрөг, n=19



Стартапын амжилт

ДСЭТ-ын аргачлалд стартапын амжилтыг өсөлтийн үе шатны амжилт, гарах хурд, эхэн шатны амжилт гэсэн үндсэн гурван үзүүлэлттээр үнэлдэг.

ӨСӨЛТИЙН ШАТНЫ АМЖИЛТ	ГАРАХ ХУРД	ЭХЭН ШАТНЫ АМЖИЛТ
Өсөлтийн шатны амжилтыг А-С ангиллын стартапын тоо болон юникорнын тоогоор хэмждэг.	Гарах хурдыг гарах үеийн компанийн дундаж нас болон анхдагч зах зээлд хувьцаагаа санал болгох үеийн компанийн дундаж насаар тодорхойлдог.	А-В ангиллын стартапын тоогоор эхэн шатны амжилтыг илэрхийлдэг.

Мэдээллийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан энэхүү судалгаагаар стартапын амжилтыг ДСЭТ-ын аргачлалд үндэслэн үнэлэх боломжгүй юм. Хөгжлийн эхэн шатандаа байгаа учраас өсөлтийн шатны амжилтыг үнэлэхэд хэтэрхий эрт байгаа бөгөөд мөн Монгол улсад одоогоор юникорн төрөөгүй байна.

Энэ удаагийн судалгааны үр дүнгээс харахад хэсэгчлэн гарах хурд нь 5 жил орчим (хамгийн ихдээ 11 жил) байгаа ба анхдагч зах зээлд хувьцаагаа санал болгох үеийн компанийн дундаж нас нь 6 жил орчим байна.

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Crunchbase Data мэдээллээр 2021 оны эхний хагаст В ангиллын стартапуудын дэлхийн дундаж нь 30 сая ам.доллар (медиан нь 40 сая орчим ам.доллар), харин А ангиллын стартапуудын дэлхийн дундаж 15 сая орчим ам.доллар (медиан нь 10 сая ам.доллар) байжээ. Энэ удаагийн судалгааны үр дүнгээс харахад В ангилалд орсон компани одоогоор байхгүй. Гэхдээ А ангиллын медианд үндэслэн тооцож үзэхэд удалгаанд оролцсон стартапуудаас багадаа 3 нь А ангиллын санхүүжилтийг босгож чаджээ. Үүнд Монгол НФТ нь анхдагч токен санал болгох замаар 14.2 сая орчим ам.долларын, Койн Хааб анхдагч койны зах зээлээс 10 сая ам.долларын хөрөнгө оруулалт босгожээ. Түүнчлэн хэвлэлийн мэдээллээс харахад Анд Глобал нь Марубенээс 10 сая ам.долларын хөрөнгө оруулалт авчээ (энэ удаагийн судалгаанд Анд Глобал компанийг стартап бус инкубатор / хөрөнгө оруулагч байдлаар хамруулсан болно). Энэ нь Монгол улсын стартапын экосистем хөгжлийн эхэн шатандаа байгаа учраас стартапуудын хөгжлийг дэмжих тааламжтай экосистемийг бүрдүүлэх нь чухал гэсэн бидний дүгнэлтийг баталгаажуулж байна.

III. Санхүүжилт

ДСЭТ-д санхүүжилтийг эхэн шатны санхүүжилтийн үзүүлэлтээр (Сийд (Seed) болон А ангиллын санхүүжилтийн дүнгээр) тооцдог бөгөөд шинээр хөгжиж буй экосистемд зориулсан ДСЭТ-ын аргачлалаар санхүүжилтийг хүртээмж, түүний дотор эхэн шатны санхүүжилтийн нийт хэлцлийн тоо ба дүнг тоо хэмжээ, хөрөнгө оруулагчдын туршлага, үйл ажиллагааны чиглэл зэрэг чанарын үзүүлэлтээр авч үздэг. Хөрөнгө оруулагчдын талаарх мэдээлэл байхгүйгээс энэ удаагийн судалгаанд санхүүжилтийн чанарыг авч үзээгүй болно. Гэхдээ бид Монгол дахь стартапын санхүүжилтийн талаарх дэлгэрнэгүй мэдээлэл өгөхийн тулд анхны болон явцын санхүүжилтийн талаарх мэдээллийг энэхүү тайланд орууллаа.

А ангиллын санхүүжилт буюу А ангиллын хөрөнгө оруулалт нь стартап компанийн сийд үеийн дараа, В ангиллын санхүүжилтийн өмнө хийгддэг. "А ангилал" гэдэг нь хувьцаагаа зарсан ангилал хамаардаг. Стартапууд А ангиллын санхүүжилт авахын тулд хамгийн бага амьдрах чадвартай бүтээгдэхүүнтэй (MVP) гэдгээ харуулах хэрэгтэй байдаг. Гүйцэтгэлийн бүлэгт дурдсанаар А ангиллын дэлхийн дундаж нь 15 сая ам.доллар, медиан нь 10 сая ам.доллар байжээ. Гэхдээ А ангиллын дундаж нь бүс нутаг, экосистемээр ялгаатай байдаг гэдгийг дурдах нь зүйтэй.

Гүйцэтгэлийн бүлэгт дурдсанчлан судалгаанд зөвхөн 2 стартап нь А ангиллын дэлхийн медиан (10 сая ам.доллар)-аас санхүүжилт босгосон бөгөөд В ангиллын санхүүжилт босгосон стартап одоогоор байхгүй. Гэхдээ хэрэв бид эхэн шатны санхүүжилтийн тодорхойлолтыг өргөжүүлэх замаар сийд санхүүжилт болон А ангиллын санхүүжилтийн илүү өргөн хүрээний тодорхойлолтыг гаргаж өгвөл санхүүжилт босгох нь илүү тааламжтай болно.

Сийд санхүүжилт нь компанийн хөрөнгийг бүтнээр болон хэсэгчлэн борлуулахад стартап компанид оруулж буй анхын хөрөнгө оруулалт юм. Сийд санхүүжилтийн хувьд нийт хөрөнгийн 10%-25%-тай байдаг. Дэлхийн хэмжээнд сийд санхүүжилт хэдэн арван мянган доллараас 10 сая ам.доллар хүртэл хэлбэлздэг. Fundz.net-ийн мэдээллээс харахад 2020 онд сийд санхүүжилтийн дундаж хэмжээ 2.2 сая ам.доллар байжээ. Сийд санхүүжилтийн хувьд нийтлэг хөрөнгө оруулагчид нь анжел хөрөнгө оруулагч, хурдасгуур, микро венчур сан болон томоохон компаниуд (одоогийн үйл ажиллагаатай нь харилцан уялдаатай байдлыг үүсгэхийн тулд худалдан авдаг) байдаг.

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Энэхүү өргөн хүрээний тодорхойлолтын дагуу авч үзвэл манай судалгаанд хамаргдсан стартапууд голчлон Сийд санхүүжилтийн үе шатанд байна. Монгол улсад 50 сая ам.доллараас дээш (ДСЭТ-д дурдсан А ангиллын) санхүүжилттэй стартап одоогоор байхгүй. Тэдний дундаж санхүүжилт 2.3 тэрбум төгрөг буюу 0.8 сая ам доллар байгаа нь сийд санхүүжилтийн дэлхийн дунджаас (fundz.net-ийн дундаж 2.2 сая ам.доллар) 1.8 дахин доогуур байна.

Анхны санхүүжилт


Судалгааны үр дүнгээс харахад анхны санхүүжилтийн дүн нь 13.4 тэрбум төгрөг, анхны санхүүжилтийн дундаж нь 183 сая төгрөг байжээ.

Хүснэгт 2: Судалгаанд хамрагдсан стартапуудын анхны санхүүжилтийн хэмжээ

Үзүүлэлт	Статистик	Дүн
Анхны санхүүжилт, n=80	Анхны санхүүжилтийн дундаж хэмжээ	₮ 183С
	Анхны санхүүжилтийн дээд хэмжээ	₮ 5.7Т
	Анхны санхүүжилтийн нийт дүн	₮ 13.4Т

Санхүүжилтийн хүртээмж хүндрэлтэй асуудал хэвээр байна. Үүсгэн байгуулагчид ялангуяа хөгжлийн эхэн үе шатанд гол төлөв хувийн хадгаламж (74%), найз нөхөд гэр бүлийн дэмжлэг (25%), мөн бусад бизнесийн орлого (17%) болон дотоодын анжел хөрөнгө оруулагч нарын хөрөнгө оруулалт зэрэгт тулгуурлан компаниа байгуулж байна. Тэтгэлэг нь анхны санхүүжилтийн 11 хувийг бүрдүүлдэг бол хурдасгуур, инкубаторуудын санхүүжилт болон зээл тус бүр 6 хувийг бүрдүүлдэг байна. Дотоодын венчур сангууд болон олон улсын анжел хөрөнгө оруулагчид ховор байдаг ба эхэн шатны санхүүжилтийн ердөө 3 хувийг л тэднээс бүрдүүлжээ.

Зураг 10: Анхны санхүүжилтийн эх үүсвэр, n=80



Дэд салбараар Финтек болон Блокчэйн стартапуудын анхны санхүүжилтийг хамгийн өндөр байгаа бол үүний дараагаар AI, их өгөгдөл ба аналитик, эрүүл мэндийн технологи, боловсролын технологийн стартапууд орж байна.

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Зураг 11: Анхны санхүүжилтийн дундаж хэмжээ, дэд салбараар, сая төгрөг, n=80



Явцын санхүүжилт

Судалгаанд оролцсон стартапуудын 41 нь буюу 51 хувь нь нийт 88.9 тэрбум төгрөгийн явцын санхүүжилтийг авчээ. Стартапууд дунджаар 2 удаагийн (дээд тал нь 10) явцын санхүүжилт авсан бол явцын санхүүжилтийн дундаж хэмжээ 2.3 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 3: Судалгаанд стартапуудын тооцсноор нэмэлт санхүүжилтийн үзүүлэлт

Үзүүлэлт	Статистик	Дүн, тэрбум төгрөг
Явцын санхүүжилт, n=41	Явцын санхүүжилтийн дундаж хэмжээ	₮ 2.3Т
	Явцын санхүүжилтийн дээд хэмжээ	₮ 40.0Т
	Явцын санхүүжилтийн нийт дүн	₮ 88.9Т

Компанийн венчур сан, гадаадын венчур компани, краудфандинг платформ зэрэг шинэ төрлийн хөрөнгө оруулагчид явцын санхүүжилтийн илүү боломжит эх үүсвэр болж байна. Амжилттай явж байгаа зарим стартапууд олон улсын томоохон корпораци болон дотоодын венчур сангуудаас 40 тэрбум төгрөгийн санхүүжилтийг босгосон байна. Эерэг талаас нь харвал илүү олон дотоодын венчур компанийн хөрөнгө оруулагчид зах зээлд орж ирж байна. Томоохон хөрөнгө оруулагчдаас дурдвал Эм Си Эс Инвестмент, Шунхлай, ТЕСО гэх мэт байна.


Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Зураг 12: Явцын санхүүжилтийн эх үүсвэр, n=41



Стартапуудын хөгжлийн үе шатаар явцын санхүүжилтийн дундаж хэмжээг авч үзвэл орлого нь нэмэгдэж буй компаниудад хамгийн өндөр буюу 4.7 тэрбум төгрөг, түүний дараа шинэ зах зээл рүү өргөжиж буй стартапуудын хувьд 3.9 тэрбум төгрөг, харин тогтворжилтын үе шатанд хүрсэн стартапуудын хувьд 2.4 тэрбум төгрөг байжээ.

Зураг 13: Явцын санхүүжилтийн дундаж хэмжээ, хөгжлийн үе шатаар, сая төгрөг, n=41



Дэд салбараар нь авч үзвэл анхны санхүүжилттэй ижил, Финтек (9.1 тэрбум төгрөг), Блокчэйн (7.8 тэрбум төгрөг) болон AI, их өгөгдөл, аналитик (7.5 тэрбум төгрөг) хамгийн их явцын санхүүжилтийг авсан байна.

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Зураг 14: Явцын санхүүжилтийн дундаж хэмжээ, дэд салбараар, төгрөг, n=41



Стартапуудын хэлснээр санхүүжилт авахад тулгарсан гол хүндрэл бэрхшээл нь компанийн үнэлгээ (31%), хэлэлцээрийн нөхцлийг зөвшилцөх (16%) болон ажлын харилцаа тогтоох (15%) байжээ.

Зураг 15: Хөрөнгө оруулалт авахад тулгардаг гол бэрхшээл, n=80



IV. Зах зээлд нэвтрэх

ДСЭТ-ын аргачлалд шинээр үүсч буй экосистемийн зах зээлийн нэвтрэлтийг стратапын эхэн шатан дахь хэрэглэгчдэд хүрэх, олон улсын зах зээлд гарах, оюуны өмчөө эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг дараах үзүүлэлтээр үнэлдэг:

Хүснэгт 4: ДСЭТ-ын зах зээлийн нэвтрэлтийн үзүүлэлт

Үзүүлэлт	Дэд үзүүлэлт	Evaluation of Mongolian Стартапс
Дэлхийд тэргүүлэгч компани	Тэрбум долларын клуб (Юникорн) ба ДНБ-ний харьцаа	Байхгүй
	50 сая доллараас дээш үнэлгээтэй гарсан компаниудын үнэлгээ ба ДНБ-ний харьцаа	Байхгүй
	2018-2021 онд 50 сая доллараас дээш үнэлгээтэй гарсан компаниудын гарах үеийн үнэлгээний харьцаа	Байхгүй
Дотоодын зах зээлд хүрэх	Тухайн улсын ДНБ	₮ 43 тэрбум
Чанар	Бодит оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулсан байдал (1-ээс 10 хүртэлх шатлалаар, олон улсын оюуны өмчийн индекс дээр үндэслэсэн оноо, улс орны түвшинд тооцогддог)	хамааралгүй

Мэдээллийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан Монгол улсын стартапын зах зээлийн нэвтрэлтийг ДСЭТ аргачлалын дагуу тооцоолох боломжгүй юм. Гэхдээ бид одоогийн нөхцөл байдлыг стартапууд зорилтот зах зээлийн хэмжээг хэрхэн төсөөлж байгаа, зорилтот зах зээл дээр хэчнээн хувийг эзэлж байна гэж үзэж байгаа, стартапуудын борлуулалтын орлого зэрэг нэмэлт үзүүлэлтээр Монголын зах зээлд стартапуудын гүйцэтгэх үүрийг харуулахыг хичээсэн. Үүн дээр нэмээд бид стартапууд дэлхийн зах зээлд гарах төлөвлөгөөтэй байгаа эсэх, тэд аль улсыг зорилтот зах зээл гэж үзэж байгаа, олон улсын зах зээлд гарахад ямар асуудалтай тулгарч байгаа зэргийг асуусан.


Дотоодын зах зээл

Судалгаанд оролцсон стартапуудын жилийн нийт орлого нь 60.2 тэрбум байна. Энэхүү судалгаанд стартапуудын дундаж орлого нь 952 сая төгрөг байжээ.



Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Зураг 16: Технологид суурилсан стартапуудын зах зээлийн ангилал, n=80




Судалгаанд үндэслээд стартапууд өөрсдийн зах зээлийг хамгийн түрүүнд B2C (75.3%) гэж тодорхойлсон бол үүний дараа B2B (65.4%), B2G (18.5%) зах зээл гэж тодорхойллоо (нэг стартап хэд хэдэн төрлийн үйлчлүүлэгчид үйлчлэх боломжтой учраас энэ давхардсан тоо болно).

Стартапууд нийт дотоодын зах зээлийг ерөнхийдөө 11.1 их наяд байна гэж үзэж байгаа нь ДНБ-ний 26 хувьтай тэнцэж байна. Дунджаар стартапууд дотоодын зах

зээлийн нэвтрэлтийн хувьд өөдрөг үзэлтэй байгаа бөгөөд тэд өөрсдийн салбартаа зах зээлийн 15 хувийг (дээд тал нь 80%) эзэмшиж байгаа гэж үзэж байна.

Орлогоороо тэргүүлэх 5 дэд салбар нь Финтек (₮ 36.9 төгрөг), Зар сурталчилгаа ба маркетингийн технологи (₮ 9.7 төгрөг), Блокчэйн (₮ 3.4 төгрөг), Боловсролын технологи (₮ 3.4 төгрөг), AI, их өгөгдөл ба аналитик (₮ 3.2 төгрөг) байна. Санхүүгийн үйлчилгээний хэрэгцээ өндөр байгаа нь Финтекийн салбарын орлого өндөр байгаад нөлөөлж байгаа бол томоохон компаниудтай ажилладаг учраас зар сурталчилгааны болон маркетингийн технологийн стартапуудын орлого байхад нөлөөлж байна.

Зураг 17: Орлогоороо тэргүүлж буй стартапын 5 дэд салбар, орлогоор (сая төгрөг.)



Судалгаанд оролцсон стартапуудын 75 хувь нь орлого олж эхэлсэн байна. Тэдний 64 хувь нь эхний жилдээ орлого олж эхэлсэн бол 15 хувь нь хоёр дахь жилдээ, 21 хувь нь гурав ба түүнээс дээш жилдээ орлого олж эхэлжээ. Орлого олж эхлэхэд дунджаар 1.8 жил, харин ашигтай ажиллаж эхлэхэд дунджаар 3.3 жил болжээ.

Орлого олж эхлэх дундаж хугацаа

1.8 жил

Ашигтай ажиллаж эхлэх дундаж

3.3 жил

Дэлхийн зах зээл

Стартапуудын 21.3 хувь нь АНУ, Япон, Солонгос, Төв Ази, Филиппин зэрэг улс орны олон улсын зах зээлд орсон эсвэл орох төлөвлөгөөтэй бай байна. Эдгээр стартапуудаас 65 хувь нь зах зээлийн судалгаагаа хийсэн байна.

Хүснэгт 5: Гадаадын зах зээлд нэвтрэх, өрсөлдөхөд тулгарах гол асуудлууд

Үзүүлэлт	Хувь
Гадаадын зөв түншийг олох	55%
Санхүүгийн дэмжлэг	54%
Хууль, дүрэм журам	30%
Бүтэгдэхүүний дасан зохицол	23%
Хэлний бэрхшээл	16%
Соёлын ялгаа	15%
Татварын ялгаа	9%

Гадаадын зах зээлд нэвтрэх, өрсөлдөхөд тулгардаг гол асуудлууд нь **гадаадын зөв түншийг олох (55%), санхүүгийн дэмжлэг (54%), хууль тогтоомжууд (30%)** байна.

V. Туршлага, авьяас мэдлэг

ДСЭТ-д туршлагыг экосистемд оролцогч стартапуудын стартап байгуулахаас өмнөх үеийн туршлагаар, авьяасыг програм хангамжийн инженерчлэлийн мэргэжлийн хүртээмж, чанар, өртгөөр, мэдлэгийг патент, судалгаа бодлого зэргээр үнэлдэг.

Хүснэгт 6: ДСЭТ дахь туршлага ба авьяасын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Монголын стартапын үнэлгээ
Туршлага: Экосистем дэх стартапын туршлагын түвшин	
Экосистем дахь стартапын туршлага:	
А ангиллын санхүүжилт	Нийт: \$ 24.6 сая (₮ 70 тэрбум) дэлхийн медиан үзүүлэлт 10 сая ам.доллар (Crunchbase)-тай харьцуулахад
Экосистем дахь ахисан түвшний туршлага:	
1 тэрбум доллараас дээш үнэлгээтэй гарсан компанийн тоо	Байхгүй. Монголд Юникорн төрөөгүй байна.
50 сая доллараас дээш үнэлгээтэй гарсан компанийн тоо	Байхгүй. 50 сая доллараас дээш үнэлгээтэй гарсан компани байхгүй.
Авьяас: Эхэн шатны стартапуудын авьяас мэдлэгийн ашиглах хүртээмжийн үнэлгээ	
Чанар ба хүртээмж:	

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Үзүүлэлт	Монголын стартапын үнэлгээ
50 сая доллараас дээш үнэлгээтэй гарсан компанийн тоо	Байхгүй. 50 сая доллараас дээш үнэлгээтэй гарсан компани байхгүй.
Github топ код бичигч нарын нийт Github код бичигч нарын тоонд эзлэх хувь	Байхгүй. Github-ийн статистик мэдээллээр (https://github.com/) 395 хэрэглэгч бүртгэлтэй байгаа (дэлхийд #111) ба тэд 2,399 дагагчтай (дэлхийд #95) байна. Топ код бичигч нарын жагсаалтад ороогүй байна.
Github.com дээр 10-аас дагагчтай код бичигч нарын тоо	Тодорхой мэдээлэл байхгүй байна. Нэг хэрэглэгч дунджаар 6 дагагчтай байна.
Мэргэжлийн Англи хэлтэй програм хангамжийн инженерүүдийн эзлэх хувь	30%, ярилцлагын үеэр өгсөн хариултад үндэслэсэн.
Өртөг:	
Програм хангамжийн инженерүүдийн сарын дундаж цалин	₮ 2.2 сая
Санхүүжилтийн хүртээмж: А ангиллын санхүүжилтийн медиан болон програм хангамжийн инженерийн дундаж цалингийн харьцаа	30 сар. Монголд сийд санхүүжилтийн медиан хэмжээ ₮ 66.5 сая төгрөг байгааг програм хангамжийн инженерийн сарын дундаж цалин ₮ 2.2 сая-д хувааж тооцсон. Өөрөөр хэлбэл, стартапууд медиан санхүүжилтээр нэг програм хангамжийн инженерийн 30 сарын цалинг төлөх боломжтой гэсэн үг.
Амьдралын шинжлэх ухаан:	
ШУТИМ оюутнууд: ШУТИМ оюутнуудын тоо	~ 9000-9500 (2020 онд)

Туршлага

Стартапын үүсгэн байгуулагч нарын боловсролын түвшин өндөр байна. Тэдний 48 хувь ахисан түвшний, 44.6 хувь нь ШУТИМ зэрэгтэй байна. **Үүсгэн байгуулагчид дунджаар 2.4 стартапыг байгуулсан байна.** Үүсгэн байгуулагчид ажиллаж буй салбартаа дунджаар 6.4 жил, бусад салбарт 6.9 жил ажилласан мэргэжлийн туршлагатай байна.




Хүснэгт 7: Үүсгэн байгуулагч нарын хувийн давуу тал, n=80

Үүсгэн байгуулагч нарын хувийн давуу тал	Хувь
Салбарын туршлага/мэдлэг	77%
Холбоо сүлжээ	57%
Манлайллын ур чадвар	56%
Гадаад хэл	38%
Санхүүгийн менежментийн туршлага/мэдлэг	28%
Гадаадад ажилласан туршлага	26%
Хуулийн мэдлэг	14%
Бусад	15%

Үүсгэн байгуулагч нарын 77% нь стартапаа байгуулахад салбарын туршлага, мэдлэг, 57% нь холбоо сүлжээ, 56% нь манлайллын ур чадвар, гадаад хэлний (38%) тусалсан гэж хариулжээ.

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа Авьяас мэдлэг

Авьяас мэдлэгийг програм хангамжийн инженерчлэлийн мэргэжлийн хүртээмж, чанар, өртөгөөр тодорхойлдог. Судалгаанаас харахад чадвартай програм хангамжийн инженер ихээхэн дутагдалтай байна. Стартапууд өөрийн багтаа дунджаар таван мэдээллийн технологийн мэргэжилтэнтэй (дээд тал нь 30), үүнээс хоёр нь (дээд тал нь 12) мэргэжлийн гадаад хэлний хэлний мэдлэгтэй байна. Стартапуудын 78% нь багтаа мэдээллийн технологийн мэргэжилтэнтэй байгаа ч, мэргэжлийн ур чадвартай мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг олж авах, ажиллуулах нь хамгийн гол бэрхшээл гэж тодорхойлж байгаа юм. ҮСХ-ны хувийн салбарын сарын дундаж цалинтай (2020 онд 1.5 сая төгрөг) харьцуулахад мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн сарын дундаж цалин 46.7%-аар өндөр буюу 2.2 сая төгрөг байна.



Стартапуудын 64% нь мэдээллийн технологийн мэргэжилтнүүдээ хувийн нэтворкинг харилцаагаараа дамжуулан олж авч, 25% нь их сургуулиудаас элсүүлж, 6% нь хүний нөөцийн компаниудаар дамжуулан, 3% нь код бичдэг курс хичээл зэргээр, 1% нь Github-аас 19% нь зар зэргээс олж авч байна.

Зураг 18: Мэдээллийн технологийн мэргэжилтнийг ажил авдаг арга зам, n=80



Стартапуудад хамгийн чухал хэрэгцээтэй байгаа таван голлох ур чадвар нь бүтээлч сэтгэлгээ, стратеги төлөвлөлт, код бичилт, үйл ажиллагааны болон манлайллын ур чадвар, дата анализ ур чадварууд болж байна.

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Зураг 19: Багт хамгийн их шаардлагатай ур чадвар, n=80



Оюуны өмч

Стартапуудын 43% нь дотооддоо 360, олон улсад 10 оюуны өмч бүртгүүлсэн бөгөөд бүгд арилжааны зориулалтаар ашиглагдаж байна. Стартапууд дунджаар 15 оюуны өмч (дээд тал нь 40) бүртгүүлсэн байна. Стартапууд шинэ санааг оюуны өмч гэж баталгаажуулах, баталгаажуулах процессыг 1 (ямар ч төвөгтэй биш) - 10 (маш төвөгтэй) оноогоор 4.7-оор үнэлэв.

Стартапуудын дурдсанаар Монгол улсад оюуны өмчийн зохицуулалттай холбоотой дараах хүндрэл бэрхшээл байна.

- **Оюуны өмч бүртгэлийн үйл явцын үргэлжлэх хугацаа хэт урт байна.** Зарим тохиолдолд зөвхөн хариу ирэхэд 6 сар зарцуулдаг. Тэд удаан хугацааны туршид оюуны өмч хулгайд өртөх эрсдэлийг мэдэрсэн.
- **Зохицуулалт тодорхойгүй байна.** Дижитал бүтээгдэхүүнийг хэрхэн бүртгүүлэх тухай зохицуулалт байхгүй. Жишээлбэл, эх код хэрхэн хамгаалагдсан нь тодорхойгүй байна. Нэг гарааны компани лого, нэр нь англи эсвэл монгол аль нь байх ёстойг ойлгохгүй байна.
- **Стартапуудын үйл явцын эхний тайлбар нь хангалтгүй бөгөөд ил тод биш юм.** Оюуны өмч бүртгүүлэхэд шаардагдах баримт бичгийн бүрэн жагсаалт тодорхойгүй байна. Зөвлөгөө өгөх үйлчилгээ байхгүй. Процессын явцад тэд хэд хэдэн удаа лавлагаа авах шаардлагатай бөгөөд үүнийг хэрэгжүүлэхийн тулд тэд хэд хэдэн удаа тийшээ явах шаардлагатай болдог.
- **Хүнд суртал их бий.** Удаан хугацааны үйл явцаас гадна стартапууд албан тушаалтнууд оюуны өмч бүртгүүлэх дургүй байгааг мэдэрсэн. Цаашлаад хоёр хүний нэр өгсөн атал нэг зохиолчийг бүртгэсэн зэрэг алдааг албаныхан гаргадаг. Албан тушаалтнуудад бүтээгдэхүүнээ ойлгох мэдлэг, чадвар дутмаг.

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

- **Хэт олон баримт бичиг.** Стартапууд оюуны өмч бүртгэлд хэт олон хамааралгүй мэдээлэл шаардагддаг бөгөөд тэдний маягт нь зохисгүй дизайнтай хэт олон хамааралгүй асуултуудтай байгааг дурджээ.
- **Автоматжуулалт байхгүй.** Мөн гарааны бизнес эрхлэгчид онлайнаар бүртгүүлэхийг хүсэж байна.

Мөн тэд Монголд оюуны өмчийн эрхийг хамгаалах нь маш хангалтгүй гэж үзсэн. Монгол улс төрийн хувьд оюуны өмчийн эрхийг хамгаалах чадамжгүй байна.

Оюуны өмчийн бодлого зохицуулалт

2020 онд батлагдсан Монгол улсын Оюуны өмчийн тухай хуульд оюуны өмчийг дараах байдлаар тодорхойлсон байна:

“Оюуны өмч” гэж оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон зохиогчийн эрхийн бүтээл, түүнд хамаарах эрхийн объект, үйлдвэрлэлийн өмчийн эрхийг;

Стартапыг дэмжих татаас болон засгийн газрын хөтөлбөрүүд, бага татвар бүхий бизнест ээлтэй орчин нь Сингапурт сүүлийн жилүүдэд бизнес эрхлэлт улам идэвхжих, өсөн нэмэгдэхэд хүргэсэн байна. Сингапурт Google, Facebook, Microsoft, LinkedIn, Строюуны өмч зэрэг дэлхийн олон технологийн аварга компаниуд оффистой бөгөөд Сингапурыг технологийн компаниудыг холбосон бүс нутгийн төв болгох асуудлыг Засгийн газар нь онцолжээ. Сингапурын Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн мэдээлснээр үндэстэн дамнасан технологийн корпорацуудын 59% нь Сингапурт бүс нутгийн төв оффисоо нээсэн байна. Засгийн газар нь олон улсын харилцаа холбоог байнга дэмжиж, хөгжүүлдэг. Нээлттэй инновацийн нетворк (**Open Innovation Network**) нь стартапүүд болон илүү өргөн хүрээний инновацийн экосистемийн хооронд шинэлэг шийдлүүдийг хамтран хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагдсан бол Глобал инновацийн холбоо (**Global Innovation Alliance**) нь бизнесийн олон улсын хөгжлийг дэмждэг байна. Энэхүү хүчин чармайлт Carro болон Patsnap зэрэг алдартай юникорнуудыг олон улсын тавцанд гарахад нь түлхэц болсон. Carro нь 2021 оны 6-р сард 360 сая ам.доллар, Patsnap юникорн нь 2021 оны 3-р сард 300 сая ам.долларын үнэлгээтэй байв.

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Засгийн газар нь аж үйлдвэржсэн улс болох үйл явцтай холбоотой **тодорхой салбаруудыг дэмжиж**, мөн deep tech технологийн салбарт анхаарлаа хандуулж байна. Сингапурын Засгийн газар дип теч (deep tech) технологийн стартапуудад оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх санаачилгын хүрээнд өнгөрсөн жил 300 сая ам.долларыг төсөвлөжээ. Улсын салбар нь мэргэшүүлэх үйл явцыг эхлүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд энэ нь эцсийн дүндээ хувийн хэвшлийг дагаж мөрдөхөд түлхэц болох юм. Үүнээс гадна дурдахад CATALYST, PIER71, ICE71, Seeds Capital, Диагностикийн хөгжлийн төв (Diagnostics Development (DxD) Hub), Үндэсний үйлдвэрлэлийн инновацийн кластер (National Additive Manufacturing Innovation Cluster (NAMIC)) болон GROW гэх зэрэг салбар бүрийн онцлогийг харгалзсан олон төрлийн байгууллага, хөтөлбөрүүд байгуулагдсан байна. Нөгөө талаар, улсын байгууллагаас хэт их хамааралтай байх нь стартап эрхлэгчдийг бэлэнчлэх сэтгэлгээнд хүргэж байна. Баримтыг сөхвөл, стартап эрхлэгчдийн 69% нь засгийн газрын буцалтгүй тусламж, татаас авчээ. Хувийн хөрөнгө оруулагчид стартапт хөрөнгө оруулах, зах зээлд суурилсан экосистемийг бий болгоход төдийлөн сонирхохгүй, үүнд чиглэсэн урамшуулал байхгүй байна.

Сингапур нь санхүүгийн төв бөгөөд венчур капиталын (VC) үйл ажиллагаагаар бүс нутагтаа тэргүүлэх байр суурь эзэлсэн билээ. Темасек Холдингс (Temasek Holdings), TIF Ventures гэх зэрэг төрийн өмчийн байгууллагуудаар дамжуулан хамтран хөрөнгө оруулалт хийх, мөн хамтын сангуудыг (VC) үүсгэн байгуулах замаар Засгийн газар нь энэ чиглэлээр томоохон үүрэг гүйцэтгэсэн байна. Гэхдээ санхүүжилтийн хэрэгцээ өндөр хэвээр байна, эхний үе шатны санхүүжилтээр Сингапур дэлхийн дунджаас доогуур байрлажээ. 2021 оны Дэлхийн стартапын экосистемийн тайланд (Global Стартап EcosyШУТИМ Report 2021) дурдсанаар стартапт зориулсан эхний үе шатны санхүүжилтийн дундаж хэмжээ 284,000 ам.доллар бол Сингапурт дунджаар 202,000 ам.доллар байжээ. Үүнээс гадна дараагийн шатны компаниуд санхүүжилт олоход мөн хүндрэлтэй байж болзошгүй юм. Тус улсын зах зээлийн хэмжээ бага тул олон хөрөнгө оруулагчид тус орны бус, харин бүс нутгийн хэмжээнд ажиллах шаардлагатай болдог байна.

Сингапурт бизнес эхлүүлэхэд олон төрлийн хууль тогтоомж, хязгаарлалт, дүрэм журмаар дамжуулан хатуу зохицуулалт хийдэг байна. **Оюуны өмчийн хатуу хуулиуд нь олон технологийн компаниуд Азийн өөр улс орныг сонгохгүй, харин Сингапурт байрлахаар шийдвэрлэсэн гол шалтгаануудын нэг юм.**

Сингапур нь олон улсын компаниудын эрэлхийлдэг олон төрлийн ур чадвартай, **өндөр боловсролтой ажиллах хүчинтэй** юм. Сингапур бол инженер, технологи болон бусад шинжлэх ухааны чиглэлээр мэргэшсэн дэлхийн хэмжээний олон их, дээд сургуулиудтай билээ. Засгийн газар нь судлаачид, оюутнууд, стартапууд болон үйлдвэрлэл хооронд нягт холбоо үүсгэн тогтоох зорилгоор хэд хэдэн их, дээд сургууль болон A*STAR-ийг татан оролцуулж байна. Үүнээс гадна инноваци, стартапт тулгарч буй сорилтууд болон инкубацийн хөтөлбөрүүд нь бизнес сэтгэлгээтэй бизнес эрхлэгчид гол кампусуудад компани байгуулахыг дэмждэг байна. Олон их дээд сургуулиуд олон улсын харилцаа холбоо тогтоож, бэхжүүлэх хөтөлбөрүүдтэй байна. Үүнээс гадна англи хэл Сингапурын үндсэн хэлнүүдийн нэг бөгөөд дэлхийн бусад улс

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

орнуудтай харьцуулахад илүү амархан суурьших, дасан зохицох боломжийг олон улсын мэргэжилтнүүд болон стартап эрхлэгчдэд олгодог байна.

VIII. Стартапын экосистемийг хөгжүүлэх зөвлөмж

Суурь судалгаагаар Монгол улсын экосистемийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх 4 үндсэн чиглэлийг тодорхойлсон болно.

Стартапын эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлого, зохицуулалт

Стартапын экосистемийг хөгжүүлэхэд Засгийн газрын хүсэл зорилго, оролцоо чухал юм. Энэ байр суурийг олон улсын хандивлагч байгууллагууд болон бүх оролцогч талууд дэмжиж байна. Засгийн газрын хүчин чармайлтын ач холбогдлыг харуулахын тулд бид экосистемд шаардлагатай дэмжлэг үзүүлж буй Сингапур болон Японы туршлагыг судалсан юм. Сингапурын Засгийн газрын хүчин чармайлт нь тус улс Азийн тэргүүлэх экосистемийн нэг болох үйл явцыг хурдасгав. Засгийн газар нь хэдэн арван жилийн турш бизнесийн орчныг сайжруулах, стартапын экосистемийг бий болгоход дэмжлэг үзүүлэх олон төрлийн бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлсээр ирсэн билээ. Бизнес эрхлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгах, хөгжиж буй зах зээлтэй хөл нийцүүлэн шуурхай арга хэмжээ авч, бодлогод өөрчлөлт оруулах замаар Сингапур нь дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай стартапүүдыг төрүүлдэг бизнес эрхлэгчдийн нийгэмлэгийг хөгжүүлсэн байна. Бодлогын хувьд 1990 оноос хойш мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх, технологийн үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, 2005 онд Шинжлэх ухаан, технологийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, 2005 онд Судалгаа, инноваци, аж ахуйн нэгжийн (RIE) төлөвлөгөө болгон өргөжүүлэн хэрэгжүүлэх зэрэг бодлогын арга хэмжээ авснаар стартапын экосистемийн цаашдын хөгжлийн гол чиглэлүүдийг тодорхойлон бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжтой юм. Одоо хэрэгжиж буй RIE 2025 төлөвлөгөөнд стартапыг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг тэргүүлэх чиглэлүүдийн нэг болгон олон нийтийн судалгааг энэхүү асуудалтай холбон чиглүүлэхийг чухалчилсан байна. Ингэхдээ ирээдүйд Сингапурын эдийн засаг, нийгэмд чухал үүрэг гүйцэтгэх инновацийг эрчимжүүлэхийн тулд дип тех (deep tech) технологийн стартапүүдэд (AI, квант тооцоолол, дэвшилтэт материал эсвэл био технологи) онцгой анхаарал хандуулдаг байна.

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

“Сингапурын гарааны бизнесийн экосистем, түүний хөгжил нь зах зээлийн өөрчлөлтөд хариу барих чадвар, хурд, шуурхай байдлаараа алдартай. Үүний нэг жишээ нь бизнест нөлөөлж болзошгүй зохицуулалтыг уялдуулан оновчтой болгохын тулд төрийн байгууллагууд цугларч зөвлөлддөг талбар, өөрөөр хэлбэл засгийн газар хоорондын байгууллагыг Худалдаа, аж үйлдвэрийн яамны дэргэд байгуулсан байна. Тус зөвлөлдөх талбар нь Анхлан алхагчийн хүрээ, шинэ санааны схемийг бий болгосон. Энэхүү тогтолцоо нь бизнес эрхлэгчдэд улсын салбараас дэмжлэг авах боломжийг олгодог бол төрийн байгууллагуудад бизнесийн шинэ санааг хэрэгжүүлэхэд тусалдаг байна.”

Сингапурын гарааны бизнесийн экосистем ба түүний хөгжил: хөгжиж буй орнуудад зориулсан сургамж, Дэлхийн банк (2021 оны 3-р сар)

Үүнтэй адилаар шинжлэх ухаан, технологийн инновацийн үндэсний систем нь хөгжсөн тул Токиогийн экосистем дэлхийн дип теч (deep tech) технологийн тэргүүлэгч төв болж өргөжин тэлэх асар их нөөц бололцоотой гэж Дэлхийн банкнаас гаргадаг Токиогийн стартапын экосистемийн тайланд (2021) дурджээ. Энэхүү систем нь судалгаа, хөгжлийн (R&D) эрчимтэй арга хэмжээ, их дээд сургуулиудын оролцоо, арилжааны шинж чанарыг өсгөх үйл ажиллагаа, өндөр өрсөлдөх чадвартай дип теч (deep tech) технологийн үйлдвэрлэл, чанартай инноваци, стартапын бүтээгдэхүүн, үндэсний хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөрүүдэд төрөөс үзүүлж буй хүчтэй дэмжлэг зэргийг багтаасан байна. Засгийн газар нь шинэ дижитал технологи, түүнчлэн хиймэл оюун ухаан (AI), робот ашигласан бизнесийн шинэ загваруудыг нэвтрүүлэх, хүртээмжтэй эдийн засгийг тэлэх, финтекийг хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх болон нийгмийн асуудлуудыг тэнцвэртэй байдлаар шийдвэрлэхэд чиглэсэн, хүн төвтэй нийгмийг төлөвшүүлэх “Нийгэм 5.0” зэрэг бодлогыг тодорхойлсон байна..

Өөр нэг сайн жишээг дурдвал Бизнес эрхлэх хялбар байдлын тайланд 11-р байр; Дэлхийн банкнаас гаргадаг Бизнес эрхлэлтийн тайлангийн Бизнес эхлэх үйл ажиллагаа гэсэн үзүүлэлтээр дэлхийд 2-р байранд орсон Литва улс юм. Литва нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь хэмжээгээр Европын Холбоонд 3-т ордог байна. Литва, ялангуяа нийслэл хот Вильнюс нь финтекийн салбарт өөрийн гэсэн орон зайг бий болгож, дэлхийн финтекийн зэрэглэлээр 4-т жагссан байна. Вильнюс хот финтекийн стартапуудыг үүсгэн байгуулах, хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, хамгийн том финтек тоглогчдын нэг болох Revolut-ийг өөртөө татаж чаджээ. Засгийн газрын дэмжлэг нь эхлэлтийн өмнөх, эхлэлтийн, өргөжилтийн гэх зэрэг стартапын хөгжлийн үе шатаас хамааран өөр өөр байдаг байна, мөн үндэсний болон олон улсын янз бүрийн бүтэц, аж ахуйн нэгжүүд дэмжих үйлчилгээгээ санал болгодог. Эдгээр байгууллагууд нь Литва улсын Засгийн газар, урьдчилсан хурдасгагч ба хурдасгагч, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчид, инкубатор/төвүүд, хамгаалалттай хязгаарлагдсан орчин (sandboxes), дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд юм.

Монголын Засгийн газар эдгээр болон бусад амжилттай стратегиуд дээр тулгуурлан стартапын экосистемийг дэмжих хүсэл эрмэлзлээ тодорхойлон, хүчин чармайлт гаргах боломжтой юм.

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Энэхүү тайлангийн үр дүнг танилцуулсан хоёр удаагийн хэлэлцүүлгийн үеэр инновацийн шилжилтийг сайжруулах зорилгоор Инновацийн тухай хуулийг шинэчлэх, Монголын экосистемийг хөгжүүлэх дэлхийн чиг хандлагыг тусгасан бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох, стартапыг олон улсын тавцанд гарахад дэмжлэг үзүүлэх, их, дээд сургууль, техникийн коллежийн дэргэдэх эрдэм шинжилгээний лабораториудад төсвийн дэмжлэг үзүүлэх зэрэг тодорхой ажлуудыг бодлогоор дэмжих нь чухал гэж оролцогч талууд санал бодлоо илэрхийлсэн болно. Харин хувийн хэвшил болон олон нийтийн байгууллагууд энэ салбарт хэт зохицуулалт хийхээс болгоомжлон, инновацийг дэмждэг төсөв, Монгол улсын Хөгжлийн банк зэрэг улсын санхүүгийн эх үүсвэрт хэт найдаж болохгүйг анхааруулсан. Үүний оронд Засгийн газраас ирээдүйтэй, технологийн тодорхой чиг хандлагад анхаарлаа хандуулан шуурхай бодлого хэрэгжүүлэх нь зөв гэж тэмдэглэсэн болно.

Стартапын тодорхойлолтыг тодорхой болгож, технологийн стартапт хэрэглэх шаардлагатай. Сингапурын стартапын тодорхойлолтод технологийн стартапыг тусгасан тул Засгийн газраас нь үзүүлж буй дэмжлэг холбогдох бизнесүүдэд зохих ёсоор хүрдэг байна. Мөн улс орны эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх тэргүүлэх чиглэл, тэдгээрийг дэвшилтэт технологид тулгуурлан шийдвэрлэх боломж зэргийг харгалзан Засгийн газрын бодлого тасралтгүй хөгждөг байна. Үүнд хүн амын хөгшрөлт, хүнсний аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт болон бусад зүйлс орно.

Enterprise Singapore-ийн мэдээлснээр, 2020 онд гарааны бизнесийн тодорхойлолт нь (Enterprise Singapore нь одоогийн байдлаар Сингапурын технологийн гарааны бизнесийн тодорхойлолтыг хянаж байгаа болно) технологийн гарааны бизнест хамаардаг байна, тухайлбал: а. Одоо байгаа үйлдвэрүүдийг өөрчлөх боломжтой шинэлэг технологитой байх; б. Сүүлийн 5 жилийн хугацаанд бүртгүүлсэн байх; в. Тухайн жилд 50-иас дээш хувийг хувь хүн эзэмшдэг байх; г. Хамгийн багадаа 1 хүн ажиллуулдаг байх.

Японд стартап гэсэн ойлголт илүү өргөн хүрээтэй, өөрөөр хэлбэл стартапууд нь өсөлт бүхий салбарт 10 ба түүнээс бага жил бизнес эрхэлж байгаа бөгөөд хөрөнгийн биржид бүртгэлгүй байна гэж тодорхойлжээ (White and Case: JFTC and METI Proposed Guidelines for Business with Startups, Jan 2021). Гэхдээ J-Startup хөтөлбөр нь шинэлэг технологи болон бизнесийн загвараараа дэлхийд шинэ үнэ цэнийг бүтээдэг, дэлхийд амжилттай гарсан стартапууд гэж стартапын тодорхойлолтод нэмэлт тодруулга хийж байна. J-Startup хөтөлбөрийг Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж, хиймэл оюун ухаан (AI), хиймэл оюун ухааны хяналтын технологи, IoT төхөөрөмж (IoT device) ба ICT, үйлчилгээ ба платформ, хөдөлгөөнт хэрэгсэл, робот, эмнэлгийн инженерчлэл ба биотехнологи, хүрээлэн буй орчин, эрчим хүч ба нийгэм, сансар судлал, үйлдвэрлэл болон материал зэргээр стартапуудыг дэмждэг байна.

Монголд стартапыг Инновацийн тухай хуульд тодорхойлсон бөгөөд стартапын тухай ойлголтыг хязгаарлагдмал байдлаар тусгасан байна (“Шигтгээ 4: Стартапын тодорхойлолт – Монгол улсын Инновацийн тухай хууль”-ийг үзнэ үү). Энэ хуульд байгаа стартапын тодорхойлолт хуучирсан, шинэчлэн найруулах шаардлагатай гэдгийг стартапууд, судалгаа шинжилгээ болон

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

төрийн байгууллагууд хүлээн зөвшөөрч байгааг тэмдэглэх нь зүйтэй юм. Технологи хурдацтай хөгжиж байгаа өнөө үед хуульд заасан тайлбар хэтэрхий хоцрогдсон байна. Цаашилбал, стартапыг дэмжихэд туслах инновацийн тэргүүлэх чиглэл болон салбаруудыг хараахан тодруулаагүй байна. Энэ нь аль хэдийн бие даан үйл ажиллагаа явуулж буй болон Засгийн газрын аливаа нэг бүтцэд тусгайлан оролцоогүй эсвэл орох хүсэлгүй стартапуудыг хязгаарлаж байна (Зураг 22-ыг үзнэ үү).

Үүнээс гадна Инновацийн тухай хуульд бүх стартапыг төрийн байгууллагад бүртгүүлж, бүтээгдэхүүнийг нь инновацитай эсэхийг төрөөс шийдвэрлэдэг байхаар заажээ. Энэ нь аливаа ач холбогдолгүй, зөвхөн хүнд суртлыг өөгшүүлж байна.

Нэмж дурдахад стартап гэсэн ойлголтыг захиргааны болон хууль тогтоомжийн түвшинд шинээр орж ирж буй бизнестэй андуурах явдал байна. “Стартап” гэдэг үг нь монгол хэл дээр ерөнхийдөө бүх анхан шатны бизнесийг илэрхийлдэг. Төрөөс стартапыг дэмжих боломжийн талаарх асуудлыг хэлэлцэхэд энэ нь ихэвчлэн залуучуудын эрхэлж буй бизнес эсвэл өрхийн бизнесийг дэмжих асуудалтай холбогддог. Иймд бизнес эрхлэлт, инноваци/технологид тулгуурласан стартап гэсэн тодорхойлолтыг судалгаа, инноваци, стартапыг дэмжих чиглэлээр төрөөс баримталж буй тэргүүлэх чиглэлийн дагуу хууль тогтоомж, төрийн бодлогод тусгайлан оруулах шаардлагатай байна. Тодорхойлолтыг ингэж салгаж тодорхой болгосноор уламжлалт болон технологийн стартапуудад зорилтот дэмжлэг үзүүлэх боломжтой болох юм.

Эцэст нь, шинээр байгуулагдсан Эдийн засаг, хөгжлийн яам; Дижитал хөгжил, харилцаа холбооны яам нь давхардсан чиг үүрэгтэй, харин инноваци нь Шинжлэх ухаан, боловсролын яамны нэг хэсэг болж байгаа тул **стартапын экосистемийг хөгжүүлэхэд Засгийн газрын үүргийг тодорхой болгох шаардлагатай** байна. Инноваци, оюуны өмчийг бүртгэх, инновацийг бодит эдийн засагт хэрэгжүүлэх боломжийг их, дээд сургуулиудад олгоход хүнд суртлыг багасгах бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд стартапын экосистемийг хөгжүүлэхэд ямар төрийн байгууллага оролцох, ямар үүрэгтэй байх асуудлыг Засгийн газраас тодорхой болгох хэрэгтэй юм. Дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, стартапын экосистемийг дэмжих зорилгоор эдийн засаг, нийгмийн гол салбаруудыг (жишээ нь, Нийгэм 5.0) тодорхойлох, Инновацийн тухай хууль болон холбогдох бодлого, журмыг шинэчлэхэд олон улсын байгууллагаас дэмжлэг авах боломжтой юм.

Монгол улсын Оюуны өмчийн Газар нь оюуны өмчийн зохицуулалт, бүртгэлийг хариуцсан Монгол улсын төрийн байгууллага юм. Патент эсвэл прототипийг бүртгэх үйл явц ихээхэн цаг хугацаа шаарддаг байна. Хамгийн гол нь тэргүүлэгч стартапуудыг дэмжих, Монгол улс руу татахын тулд оюуны өмчийг хамгаалах тал дээр Сингапурын туршлагыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Стартап болон хөрөнгө оруулагчдыг дэмжих орчныг бүрдүүлэх

Стартапыг дэмждэг улс орнууд стартап эрхлэгчид болон хөрөнгө оруулагчдад төрөл бүрийн урамшуулал үзүүлдэг байна.

Стартапуудад хөгжлийнх үе шатанд нь тохирсон оновчтой дэмжлэг үзүүлэх хамгийн сайн жишээг Литва харуулсан байна. Литва дараах саналыг дэвшүүлсэн байна

1) **Бизнесийн менторын сүлжээ/нетворк** (эхлэлтийн өмнөх болон эхлэлтийн үе шат дахь стартап) - Туршлагатай бизнес эрхлэгчид бусад бизнесүүдтэй мэдлэгээ хуваалцдаг виртуал платформ;

2) **Enterprise Lithuania** (эхлэлтийн өмнөх, эхлэлтийн, өргөжилтийн үе шат дахь стартап) - Enterprise Lithuania баг нь бизнес эхлэх, хөгжүүлэх, экспортлоход дотоодын компаниуд, ялангуяа ЖДҮ-д зөвлөх, туслах үйл ажиллагаа явуулдаг байна. Энэхүү байгууллагын үндсэн чиг үүргийн нэг нь бизнес эрхлэгчдэд зөвлөгөө өгөх, цахим хэрэгсэл, үйлчилгээгээр хангах явдал юм. Enterprise Lithuania нь Литва дахь стартапын нийгэмлэг, экосистемд сайн танигдсан зөвлөх, чиглүүлэгч юм.

3) **Литва улсын Инновацийн төв** (эхлэлтийн өмнөх, эхлэлтийн, өргөжилтийн үе шат дахь стартап) – Литва улсын Инновацийн төвийн үйл ажиллагааг төслийн хэлбэрээр зохион байгуулдаг байна. Литва улсын Инновацийн төв нь Европын Холбоо, бусад олон улсын байгууллага, Литва улсын Засгийн газраас зарласан төрөл бүрийн тендер, саналын уралдаанд оролцдог байна. Өргөдлийг хүлээн авч, санхүүгийн дэмжлэг баталгаажсаны дараа үйл ажиллагаа явуулж, үйлчилгээ үзүүлдэг байна. Санхүүжилт татах талаар бизнесийн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлдэг болно.

4) **Тээвэр, харилцаа холбооны хамтын хөрөнгө оруулалтын сан** (эхлэлтийн болон өргөжилтийн үе шат дахь стартап) - Коинвест Капитал (Coinvest Capital) нь нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарлыг бууруулах зорилгоор тогтвортой хөдөлгөөн, байгаль орчинд ээлтэй тээврийн хэрэгслийг хөгжүүлэх чиглэлээр ажилладаг бичил болон жижиг компаниудад хөрөнгө оруулалт хийдэг байна. Хөрөнгө оруулалтын хэмжээ нь 1.6 сая евро хүртэл байна.

5) **LVPA - Experiment** (өргөжилтийн үе шат дахь стартап) –Литва улсын Бизнесийг дэмжих агентлаг нь Литва улсын бизнес, судалгаа шинжилгээ ба хөгжил (R&D), аялал жуулчлал, эрчим хүчний салбарыг хөгжүүлэхэд зориулж ЕХ-ноос олгосон санхүүжилтийг удирддаг Эдийн засаг, инновацийн яамнаас байгуулсан байгууллага юм. "Туршилт" ("Experiment") санаачилгын зорилго нь аж ахуйн нэгжүүдийг инновацийн бүтээгдэхүүнд хөрөнгө оруулах, шинэ бүтээгдэхүүн, технологи, үйлчилгээг бий болгоход шаардлагатай судалгаа шинжилгээ ба хөгжлийн ажлыг (R&D) эрчимжүүлэх, мөн судалгаа шинжилгээ ба хөгжлийн ажил, инновацийн дэд бүтцэд хөрөнгө оруулах замаар бизнесийн хөгжлийг дэмжих явдал юм. Стартапын экосистемийн амжилтын гол үзүүлэлт нь хөрөнгө оруулагчид, анжел хөрөнгө оруулагчид, венчур сангуудын хүртээмж, чанар юм. Венчур санд хандах боломжийн хувьд Япон 1-р байранд ордог байна. Японы Венчур сангийн холбоо нь 1971 онд үүсгэн байгуулагдсан байна. Softbank Vision Fund, Sony Innovation Fund, Dentsu Ventures Global Fund гэх зэрэг шинэ сангуудаар Япон улс дэлхийн стартапын экосистемийн жагсаалтын 10-р байранд оржээ.

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Сингапур нь бүс нутгийн санхүүгийн төв, үндэстэн дамнасан банкнууд, хөрөнгийн менежментийн компаниуд болон сүүлийн үед венчур сангуудын өлгий нутаг болжээ. Сингапурыг бүс нутгийн инноваци, стартапын төв болгон хөгжүүлэх зорилгоор Засгийн газар нь арга хэмжээ авч байгаа тул хөрөнгө оруулалт өндөр хэвээр байхаар байна. Эдгээр арга хэмжээнд Засгийн газраас хувийн хөрөнгө оруулалтыг холбож буй хамтын санхүүжилтийн схемүүд багтана, жишээлбэл SEEDS Capital-ийн (Enterprise Singapore-ийн хөрөнгө оруулагч) санаачилгууд. 2019 оны 1-р сард SEEDS Capital нь хөдөө аж ахуйн хүнсний технологийн стартапуудад 65 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийх хамтран хөрөнгө оруулагч долоон түншийг томилсон байна.

Татвараас чөлөөлөх жишээ: Япон (Эх сурвалж: Япон дахь венчур капиталын хөрөнгө оруулалт: зах зээл ба зохицуулалтын тойм- Mori Hamada & Hatsumoto)

Ангел хөрөнгө оруулалтад зориулсан татварын тусгай урамшуулал

Гарааны бизнест хөрөнгө оруулалт хийж буй хувь хүмүүс энэхүү анжел хөрөнгө оруулалтад зориулсан татварын тусгай урамшууллыг хүртэх боломжтой юм. Хөрөнгө оруулалт хийх үед гарааны бизнест оруулсан хөрөнгө оруулалтын дүнг татвар ногдох орлогоос (татвар ногдох орлогын дээд хязгаар нь 40% буюу 10 сая иен) хасаж эсвэл бусад хувьцааны борлуулалтаас олсон хөрөнгийн ашгаас хасаж болно. Өөр нэг хувилбар бол хөрөнгө оруулалтаас гарахад хөрөнгийн алдагдлыг гурван жил хүртэл хойшлуулах явдал юм.

Хязгаарлагдмал хариуцлагатай түншлэлийн гадаадын хөрөнгө оруулагчдыг PE-ээс чөлөөлөх

Японд хязгаарлагдмал хариуцлагатай түншлэлд хөрөнгө оруулалт хийснээр хязгаарлагдмал хариуцлагатай гадаадын түншийг Японд бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа гэж үзэж болох бөгөөд Японд татварын тайлан гаргах шаардлагатай болдог. Байнгын байгууллагын (PE) асуудлаас зайлсхийхийн тулд Японы татварын дүрмийн дагуу гадаадын хөрөнгө оруулагчийг "PE" бус хөрөнгө оруулагч гэж үзэх тусгай дүрэм байдаг, тухайлбал:

- Японы сангийн 25 хувиас бага хувийг эзэмшдэг.
- Сангийн бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй.
- Гадаадын хөрөнгө оруулагч нь тухайн улсын татварын албанд урьдчилан тогтоосон хэлбэрээр мэдэгдэл гаргаж, тусгай дүрмийг хэрэглэх хүсэлтэй байгаагаа мэдэгдэнэ.

Татвараас чөлөөлөх жишээ: Сингапур (Сингапур дахь венчур капиталын хөрөнгө оруулалт: зах зээл ба зохицуулалтын тойм - Wong Partnership LLP)

1. Орлогын татварын систем нь VC болон PE-ийн хөрөнгө оруулалтыг дэмждэг байна. Аж ахуйн нэгжийн татварын нэг шатлалт тогтолцооны дагуу Сингапурын оршин суугч компани аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг төлсний дараа хувьцаа эзэмшигчид нь тухайн компанийн төлсөн ногдол ашгаас татвар төлөхгүй. Дараах бүх нөхцөл хангагдсан тохиолдолд татварын байцаагч нь оршин суугч компаниудыг гадаадаас авсан ногдол ашгийн татвараас чөлөөлдөг байна

- Гадаадад олсон орлогыг Сингапурын оршин суугч компанид төлөхөөс өмнө тухайн улсын татварын байгууллага нь татвар ногдуулсан.
- Орлогыг Сингапурт хүлээн авах үед тухайн улсын татварын байгууллагын татварын хамгийн өндөр хувь хэмжээ дор хаяж 15% байна (энэ нь гадаадын орлогод ногдуулдаг татварын бодит хувь хэмжээ байх албагүй)
- Орлогын албан татварын байцаагч нь татвараас чөлөөлснөөр оршин суугч компанид ашигтай гэдэгт итгэлтэй байна.

2. Хөрөнгөө худалдаж буй компани нь тодорхой шалгуурыг хангасан тохиолдолд хөрөнгө оруулалтыг захиран зарцуулснаар олсон орлогод хөрөнгийн орлогын албан татвар ногдуулахгүй, тухайлбал i) Хувьцааг худалдахын өмнө, хөрөнгөө худалдаж буй компани нь хөрөнгө оруулалттай компанийн хувьцааны 20%-иас доошгүй хувийг эзэмшдэг ii) Хөрөнгө оруулалттай компани нь энэхүү хувьцааг дор хаяж 24 сарын турш тасралтгүй эзэмшиж байсан ба бусад.

3. 13Н хэсгийн татварын урамшуулалд хамрагдахаар Сингапурын Enterprise Singapore (ESG)-аас баталсан VC сан, нөхөрлөл, гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд болон Сингапурын хувьсах капиталын компаниуд (VCC) нь 15 хүртэлх жилийн хугацаанд татвараас чөлөөлөгдөнө (үүний дараа 5 жилээр сунгаж болно). Дараах хөрөнгө оруулалтаас олсон орлого:

- Зөвшөөрөгдсөн хувьцааны багцыг худалдсанаас олох орлого
- Батлагдсан гадаадын компаниудын ногдол ашгийн орлого
- Зөвшөөрөгдсөн гадаад хувьцаанд хөрвөх зээлийн хүүгийн орлого
- Оффшор сангийн урамшууллын схем, Суурин сангийн урамшууллын схем, Сайжруулсан түвшний сангийн урамшууллын схемээр дамжуулан хийсэн хөрөнгө оруулалтаас олсон тодорхой орлого

Ийм дэмжлэг үзүүлснээр тодорхой үр дүнд хүрчээ. Enterprise Singapore-ийн мэдээлснээр: 2019 оны эхний есөн сарын байдлаар VC-ийн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36%-иар өсөж SGD 13.4 тэрбумд хүрсэн бөгөөд дижитал технологийн компаниуд санхүүжилтийн 93.2%-ийг авсан байна. Мөн 2019 оны эхний есөн сарын хугацаанд 2018 оны мөн үетэй харьцуулснаар дэвшилтэт үйлдвэрлэл, эрүүл мэнд, био анагаахын шинжлэх ухаан, хотын шийдэл ба тогтвортой байдал зэрэг салбарууд дахь хөгжлийн эхлэлтийн үе шатанд байгаа дип теч (deep tech) технологийн стартапуудын хөрөнгө оруулалт 25%-иар өссөн байна.

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Литва Эстони болон бусад улсад компаниудын дижитал бүртгэл хийх, санхүү болон татварын тайланг онлайнгаар авах орчныг бүрдүүлсэн байна. Мөн стартап эрхлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлдэг байна. Жишээлбэл, Эстони улсад стартапт хуримтлуулан дахин хөрөнгө оруулалт хийсэн орлогод албан татвар ногдуулдаггүй бөгөөд татварын тайланг онлайнгаар бүрэн илгээх боломжтой юм. Татварын тайланг хүргүүлэхэд ердөө 30 минут л хангалттай байна.

Өөр нэг сонирхолтой жишээ бол Португали юм, энд эхлэлтийн үе шат дахь стартапт үзүүлэх татварын гол урамшуулал нь Аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтын схемд (Enterprise Investment Scheme, Их Британи) суурилсан байна. IAPMEI (Засгийн газрын Жижиг, дунд үйлдвэрийн агентлаг) гэрчилгээтэй, 3 жилээс богино хугацаанд үйл ажиллагаа явуулсан ЖДҮ (эсвэл стартап)-д хөрөнгө оруулалт хийсэн бизнесийн ангел хөрөнгө оруулагч нь хувь хүний орлогын албан татвараа 20%-иар бууруулах боломжтой (20% -ийн хөнгөлөлт нь орлогын албан татварын 15% -иас хэтрэхгүй байх ёстой).

Стартапуудад зориулсан санхүүгийн урамшуулал нь тэргүүлэх чиглэлийн технологийн стартапыг дэмжих тусгай хөтөлбөрүүдтэй холбоотой байдаг. Гэхдээ стартапын экосистем хөгжсөн орнуудын ДНБ нь өндөр байдаг тул Засгийн газар нь ийм тусламж, татаас олгох боломжтой байдаг байна. Монгол улсын Засгийн газраас инновацид буцалтгүй тусламж олгодог бөгөөд Шинжлэх ухаан, технологийн үндэсний сангийн хүрээнд эдгээр тусламжийг ашиглаж байна.

Монгол улсын Инновацийн тухай хуульд дараах байдлаар татварын хөнгөлөлт олгосон байна: “22.5.4. Инновацийн тухай хуульд заасан болон шинээр үүсгэн байгуулсан гарааны компани бүртгүүлсэн өдрөөс хойш гурван жилийн дотор инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг борлуулсны орлогод ногдуулсан албан татварт” хөнгөлөлт тооцох гэсэн боловч Инновацийн тухай хуульд байгаа стартапын тодорхойлолтын дагуу одоогоор ердөө 27 компани үүнд хамрагдах боломжтой юм.

Стартап эрхлэгчид зөвхөн жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан татварын ерөнхий зохицуулалтаас ашиг хүртэх боломжтой. Хүргүүлэх шаардлагатай бүх санхүүгийн болон зохицуулалтын баримт бичиг нь Монголд бизнес эрхлэхэд хүндрэл учруулж байна. Үйл ажиллагааны цар хүрээ, хэмжээ, үйл ажиллагаа явуулсан жилээс үл хамааран бүх аж ахуйн нэгжүүд санхүүгийн тайлангаа хүргүүлэх шаардлагатай байдаг. Жилийн санхүүгийн тайланг эрх бүхий байгууллагаар шалгуулсан байх ёстой. Мөн нэмэгдсэн өртгийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ажиллагсдынхаа нийгмийн даатгалын шимтгэлийн тал хувийг жилд дөрвөн удаа тушаах үүрэгтэй байна.

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа
Хүснэгт 8: Аж ахуйн нэгжийн татварын зохицуулалт

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар		
ААН-ийн төрөл	Татварын хувь хэмжээ	Санхүүгийн тайлан тушаах давтамж
50 сая төгрөг хүртэлх орлоготой ААН	Ашгийн 1%	Жилд 1 удаа
300 сая төгрөг хүртэлх орлоготой ААН	Ашгийн 1%	Жилд 2 удаа
300 сая – 1.5 тэрбум төгрөгийн орлоготой ААН	Ашгийн 10%, буцаалт 90%	Жилд 2 удаа
Хувь хүний орлогын албан татвар (ажиллагчдын)		
Бүх ААН	Цалингийн орлогын 10%	Жилд 4 удаа
Нийгмийн даатгалын хураамж (ажиллагчдын өмнөөс төлөх)		
Бүх ААН	11-12%	Сар бүр

Хөрөнгө оруулалтын сан болон татварын зохицуулалтын сайжруулалт нь Монголын стартапын өсөлтийг дэмжих гол хүчин зүйлс юм. Энэхүү суурь судалгааны явцад цуглуулсан баримтуудаас харахад стартапын салбар нь ирээдүйтэй салбар бөгөөд эдийн засгийг төрөлжүүлэх гол хөдөлгөгч хүч болох юм. Хөрөнгө оруулалт болон татварын таатай орчныг бүрдүүлснээр Монгол улс гадаадын шууд хөрөнгө оруулалтыг эрчимжүүлж, технологид тулгуурласан үйлчилгээ, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэн эдийн засгийг төрөлжүүлэх боломжтой болох юм.

Стартапын экосистемийн уялдаа холбоог хангах, хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээ

Стартапын экосистемийг үүсгэн байгуулах, тухайн улс орон болон олон улсын хэмжээнд уялдаа холбоог хангахад чиглэсэн Засгийн газрын хүчин чармайлт чухал юм.

Монгол улс дахь уялдаа холбоо:

Одоогийн байдлаар стартапын экосистемийн уялдаа холбоо сайжирч байна. Гэхдээ энэхүү уялдаа холбоог цаашид улам сайжруулах, стартапын экосистемийг хөгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, боломжтой холбоотой асуудлыг шийдвэрлэхэд бүх оролцогч талуудыг илүү зохион байгуулалттайгаар оролцуулах хэрэгтэй байна.

Стартапын экосистемийн холбоо/консорциум: Стартапын экосистемийн оролцогч талууд оролцогч талуудад тулгарч буй асуудлыг хамтран хэлэлцэх боломжтой байхын тулд нэгдэх хэрэгтэй юм. Холбоо/консорциум нь Монголын стартапын экосистемийг хөгжүүлэхэд шаардлагатай оюуны өмчийн зохицуулалт, татварын орчин болон Засгийн газрын бусад дэмжлэг зэрэг асуудлаар зохицуулалтын орчинг сайжруулахад чиглэсэн санал, шийдвэрлэх арга зам бүхий судалгаа, баримт бичгүүдийг бодлого боловсруулагчид болон зохицуулагчдад

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

танилцуулах чадвартай байх шаардлагатай байна. Консорциумд бүх чухал оролцогч талуудын гол төлөөлөгчдийг оролцуулах нь зүйтэй юм. Мөн олон улсын экосистемд холбогдох хүчин чармайлтаа нэгтгэж, Монголыг стартапын газрын зурагт оруулах хэрэгтэй байна. Эхний ээлжинд Стартап Genome-ийн гишүүнээр элсэж, Монгол улсын тайланг бэлтгэн Дэлхийн стартапын экосистемийн тайланд (Global Стартап EcosyШУТИМ Report) оруулж болох юм. Тогтвортой байдлыг хангахын тулд стартапын экосистемийн гишүүд нь гишүүнчлэлийн хураамж төлж, холбоо/консорциумын үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжтой.

Стартапын экосистемийн мэдээллийн сан

Монгол улс стартапын экосистемийг хөгжүүлэх ажлын хүрээнд стартапын экосистемийн оролцогчдыг танилцуулах ил тод, хараат бус, хүртээмжтэй мэдээллийн санг бий болгох шаардлагатай байна. Мэдээллийн санг аливаа нэг этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх, харин стартапын экосистемийн бүх гишүүдэд хүртээмжтэй байлгах нь маш чухал юм. Холбоо түүний хөгжилд хяналт тавьж, бүх гишүүдийн оролцоо, хамтын ажиллагааны үр дүнд байнга шинэчилж байх боломжтой. Стартапын экосистемийн хөгжлийг хэмжих боломжтой байх зорилгоор бие даасан, хараат бус судалгааны байгууллага Холбооны албан ёсны хүсэлтийг үндэслэн жил бүр мэдээллийг шинэчилж байх ёстой юм.

Япон улсын JETRO байгууллага нь Японы стартапын экосистемийн талаарх мэдээлэл, мөн тус улсын тэргүүлэгч венчур сангуудтай хийсэн ярилцлага зэрэг хувийн хэвшлээс ирүүлсэн мэдээг гаргадаг байна. J-Start нь 10,000 стартапыг дэмжих үндсэн санаачилгадаа бүх оролцогч талуудыг нэгтгэдэг байна.

Стартап Lithuania нь стартапүүд, венчур капиталын сан, хурдасгагчид, стартапт ээлтэй компаниуд болон Засгийн газрыг хамруулсан стартапын үндэсний экосистемийг хөгжүүлдэг байна. Мөн тус байгууллага стартапын экосистемийн тухай мэдээ нийтлэх, стартапын мэдээллийн сан болон хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, стартап болон стартапын ажиллагчдад зориулсан визний хөтөлбөрийг удирдах, стартап эрхлэгчдэд зориулсан жилийн чухал арга хэмжээ болох хакатон, семинар, танилцуулах үзэсгэлэн (Стартап Fair) зэрэг арга хэмжээг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Үүнээс гадна стартапын экосистемийн хамгийн сайн мэдээллийн санг бүрдүүлэн ажиллуулж байна. Иймд Улаанбаатар хотыг стартапын экосистемийн төв болгоход Литва улсын туршлагыг Монгол улсад хэрэгжүүлэх нь зүйтэй юм (<https://www.Стартапlithuania.com/Стартап -ыг> үзнэ үү).

Эстони улс идэвхтэй, нээлттэй, дэмжлэг үзүүлэхүйц стартапын экосистемтэй бөгөөд зорилго бүхий хүмүүс болон стартапуудыг дэмждэг байна. Тэд нийтдээ Эстони улсын 110 байгууллагатай хамтран ажиллаж, стартапуудад өргөн хүрээний үйлчилгээ үзүүлдэг байна. "Startup Estonia" цахим хуудас нь "Startup Lithuania"-тай төстэй табуудыг санал болгож байна. Цахим хуудсанд Эстонийн стартапын мэдээллийн санг байршуулсан бөгөөд стартапын хөгжлийн үе шатанд (эхлэлтийн сэтгэлгээ, эхлэлтийн өмнөх, эхлэлтийн, өргөтгөлийн үе шат) нийцүүлэн үзүүлэх тусламжийн төрлүүд гэсэн таб байдаг байна.

Стартапын экосистемийн олон улсын харилцаа холбоо

Олон улсын стартапын экосистем, зах зээлтэй холбоотой байх нь стартапыг хөгжүүлэх чухал хүчин зүйл юм. Ази тивийг Европтой холбосон хамгийн том улс оронд ашигтай хүчин зүйлс их юм. Олон улс оронд стартапын үйл ажиллагааг олон улсын тавцанд гаргах, хурдасгагч, инкубатораар дамжуулан чадавхыг нь бэхжүүлэх зэрэг дэмжлэг үзүүлдэг байна. Япон, Сингапур гэх зэрэг бусад экосистемтэй хамтран ажиллах нь манай экосистемийн өсөлтөд бодит түлхэц болж, дэлхий дахинд өөрсдийн боломжоо харуулах арга зам болох юм.

Стартап олон улсын тавцанд гарахад нь үзүүлэх хамгийн том дэмжлэг бол улсынхаа экосистемийг олон улсын бизнесийн гол тулгуур болгох, мөн цар хүрээгээ тэлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх стартапын хүсэл эрмэлзлийг дэмжих явдал юм. Сингапур Дэлхийн Банкны Бизнес эрхлэлтийн индексээр 1-р байранд орж, Google, Facebook, Microsoft, LinkedIn, Строюны өмч зэрэг дэлхийн олон технологийн аваргуудыг татсан бүс нутгийн төв болсон байна. Сингапурын Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн мэдээлснээр үндэстэн дамнасан технологийн корпорацуудын 59% нь Сингапурт бүс нутгийн төв оффисоо нээсэн байна.

Япон улсын JETRO байгууллага нь Японы стартапын экосистемийн талаарх мэдээлэл, мөн тус улсын тэргүүлэгч венчур сангуудтай хийсэн ярилцлага зэрэг хувийн хэвшлээс ирүүлсэн мэдээг гаргадаг байна. J-Start нь 10,000 стартапыг дэмжих үндсэн санаачилгадаа бүх оролцогч талууд болон олон улсын хамтрагч байгууллагуудыг нэгтгэдэг байна.

Манай экосистемтэй төстэй Литва, Эстони улсын экосистемээс бид суралцах хэрэгтэй юм. Эдгээр экосистемүүд нь стартапын тэргүүлэгч экосистем болсон бөгөөд гайхалтай амжилт гаргаж чадсан байна. Эдгээр экосистемүүд олон улсын стартап эрхлэгчдэд тухайн улс оронд суурьших таатай бизнес болон хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлсэн бөгөөд дотоодын стартапуудад дэлхийн зах зээлд гарахад нь дэмжлэг үзүүлдэг байна.

EU-Startups.com сайтаас стартап эхлүүлж болох Европын эхний 3 орны тоонд Эстони улсыг оруулсан байна. Эстонийн боловсролын систем өндөр хөгжсөн, цахимжуулалт ба дижитал үйл ажиллагаа өргөн дэлгэрсэн, ажил болон бизнес эрхлэх виз авахад хялбар тул стартап эрхлэгчдийн сонирхол татдаг байна. Нэг өдрийн дотор компани байгуулахаас эхлээд татвараа гурван минутын дотор төлөх хүртэл бүх зүйлийг онлайнаар хийх цахим үйлчилгээ буюу мэдээллийн технологийн үндэсний дэд бүтэц өндөр хөгжсөн тул стартапууд Эстониог сонгох нь гарцаагүй юм.

Олон улсын стартапын экосистемтэй мэдлэг, мэдээлэл солилцох нь

Олон улсын стартапын экосистемтэй мэдлэг, мэдээлэл солилцох нь Монголын экосистемийг хөгжүүлэх бодит алхам болно. Японы стартапын экосистем нь чадвартай (Сингапурын өмнө жагсдаг), япон хэлний мэдлэгтэй олон мэргэжилтэнтэй болсон, газар зүйн хувьд харьцангуй ойр байршилтай, соёл, эдийн засгийн харилцаа холбоотой байдаг зэргийг авч үзвэл Монголын стартап эрхлэгчдэд энэхүү олон улсын харилцаа холбоо ашиг тустай нь гарцаагүй юм. Энэхүү

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

харилцаа холбоо нь Монголын стартапын зах зээлийн хүрээг мэдэгдэхүйц тэлж, Монголын анхны юникорныг гадаадын зах зээлд бий болгох боломжийг олгоно. Мэдлэг солилцох, түншлэл байгуулах зорилгоор жил бүр тодорхой арга хэмжээ зохион байгуулах нь Японы стартапүүдтэй хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм

Жишээ нь, Японы Засгийн газар 10,000 шинэлэг стартапуудад дэлхийн зах зээлд гарахад нь дэмжлэг үзүүлэх, экосистемийг бэхжүүлэх зорилгоор J-Startup хөтөлбөрийг нэвтрүүлсэн байна. Олон нийтэд таниулан сурталчлах, олон улсын томоохон арга хэмжээнд оролцоход нь туслах, зохицуулалтын хамгаалалттай хязгаарлагдсан орчны (sandbox) системийг ашиглах, зохицуулалттай холбоотой хүсэлтийг шийдвэрлэх зэргээр Засгийн газар нь дэмжлэг үзүүлдэг байна.

Японы хотууд стартапт таатай орчинг бүрдүүлэхийн төлөө өрсөлддөг байна. Жишээ нь, Шибуяад олон улсын стартап эрхлэгчид болон бүх стартап эрхлэгчдэд биечлэн зөвлөгөө өгөх, нөөцөөр хангах, орон нутаг дахь бизнесийн боломжуудтай танилцуулан холбох зорилготой "Шибуяа стартапыг дэмжих" санаачилгыг Шибуяа хотын албанаас гаргасан байна.

4. Инноваци, ажиллах хүчийг дэмжих ШУТИМ-ийн боловсролын шинэчлэл

ШУТИМ-ийг дэмжсэн боловсролын шинэчлэл нь экосистемд авьяас чадварыг авчрах гол хүчин зүйл юм. Засгийн газар нь ШУТИМ коллежуудыг хөгжүүлсэн, их дээд сургуулиуд, оюутнууд, стартапүүд болон үйлдвэрлэлийн хооронд холбоо тогтоосон Япон болон бусад орны туршлагыг судалж суралцах нь зүйтэй юм.

Сингапурт инженер, технологи болон бусад шинжлэх ухааны чиглэлээр мэргэшсэн дэлхийн хэмжээний их сургуулиуд байдаг. Засгийн газар нь судлаачид, оюутнууд, стартап эрхлэгчид болон үйлдвэрлэлийн хооронд бат бөх холбоо тогтооход чиглэсэн A*STAR хөтөлбөрөөрөө инноваци болон стартап эрхлэгчдийг дэмждэг байна. Үүнээс гадна их, дээд сургуулиуд инноваци, стартапуудад тулгарч буй сорилтыг шийдвэрлэх, инкубаторын хөтөлбөрүүдийг дэмжихийн тулд кампусуудаа зориулдаг бөгөөд олон их дээд сургуулиуд олон улсын харилцаа холбоо тогтоож, бэхжүүлэх хөтөлбөрүүдтэй байна.

Японы техникийн их, дээд сургууль, коллежийн чанартай, чадварлаг байдал нь стартапын экосистемээ богино хугацаанд дэлхийн тавцанд гаргахад тус дөхөм болсон байна. Японы инженерийн болон роботын салбар дахь давуу талыг хиймэл оюун ухаан (AI), дип теч (deep tech) технологиор сайжруулж, дип теч (deep tech) технологийн стартапыг дэмжих чадварыг бий болгосон. Үүнээс гадна Японы их дээд сургуулиуд инновацийн өөрийн сантай байна, тухайлбал Токиогийн Их Сургууль Эгдэ Капитал ХХК (Egde Capital Co Ltd, UTEC), Киотогийн Их Сургууль Инновацийн Капитал ХХК (Innovation Capital Ltd), Кейогийн их сургууль Инновацийн Санаачилга (Innovation Initiative Inc) зэрэг инновацийн сантай байна.

Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа

Мэдлэг боловсролтой, чадварлаг, мэргэшсэн боловсон хүчин бол Монголын стартапын экосистемийг хөгжүүлэх гол хүчин зүйл болно. Чадварлаг багийг бүрдүүлэх нь Монголын стартап эрхлэгчдэд тулгамдаж буй гол асуудал гэж тодорхойлсон байна. ШУТИМ мэргэжлээр элсэгчдийн тоо буурсан нь Засгийн газар ШУТИМ боловсролыг шинэчлэх үндэслэл, шаардлага болох юм. Японы үйлдвэржилт, инновацийн хөдөлгөгч хүчин зүйл нь 15 наснаас эхлэн таван жилийн инженерийн боловсрол олгодог Косэн технологийн коллежийн (Kosen Colleges of Technology) загвар болсон юм. Монгол улс ч мөн адил замаар стартапынхээ экосистемийг дэмжих чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх боломжтой билээ.